

ХОВД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

(2007 – 2015 он)

**Ховд хот
2006**

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	3
ОРШИЛ.....	4
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ	7
1.1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, салбарын зохистой бүтцийг бий болгох бодлого	7
1.2. Аж үйлдвэрийн хөгжил	12
1.3. Хөдөө аж ахуйн хөгжил	14
1.4.1. Зам тээврийн хөгжил	19
1.4.2. Эрчим хүчний салбарын хөгжил	21
1.4.3 Мэдээлэл, харилцаа холбооны хөгжил.....	22
1.5. Аялал, жуучлалын салбарын хөгжил	24
1.6. Барилга, хот байгуулалтын хөгжил	26
ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ	28
2.1. Хүн амын өсөлт, хүний хөгжлийг хангах талаар	28
2.2. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар.....	30
2.3. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар	32
2.4. Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшүүлэх талаар	36
2.5. Хэрэглээний бүтцийг сайжруулах талаар.....	39
ГУРАВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ	43
3.1. Агаар мандлын хамгаалал.....	43
3.2. Газрын нөөцийн ашиглалт, хамгаалал	45
3.3. Усны нөөцийн ашиглалт, хамгаалал.....	47
3.4. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал.....	48
3.5. Цөлжилт, гантай хийх тэмцэл	50
3.6. Биологийн төрөл зүйлийн хамгаалал	51
3.7. Байгалийн гамшгаас сэргийлэх, хохирлыг бууруулах талаар	52
ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭРЭГСЭЛ.....	54
4.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл.....	54
4.2. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл	54
4.3. Олон нийтийн оролцоо	55
ТАВ. ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮР ДҮН, ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56
А. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр.....	57
Б. Шаардлагатай санхүүгийн хэмжээ.....	57
В. Стратегийг хэрэгжүүлснээр гарах эдийн засгийн гол дүн.....	57
ХАВСРАЛТ 1. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ.....	58
ХАВСРАЛТ 2. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2006-2010 ОН)	60

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ
АХБ	Азийн хөгжлийн банк
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БЗ	Бүсийн зөвлөл
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БОЯ	Байгаль орчны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БХДСан	Боловсролын хөгжлийг дэмжих сан
БОЭТ	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалт
ГЗТ	Гадаадын зээл, тусламж
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МАО	Мал аж ахуй
МХХТГ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
СЯ	Сангийн яам
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТЭХЯ	Түлш эрчим хүчний яам
ТЭХС	Төвийн эрчим хүчний систем
УИХ	Улсын Их Хурал
УТ	Улсын төсөв
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
УЦС	Усан цахилгаан станц
ҮСГ	Үндэстний статистикийн газар
ҮХХ	Үндэстний хөгжлийн хүрээлэн
ҮХЯ	Үйлдвэр худалдааны яам
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХХХО	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
ХО	Хандивлагч орнууд
ШУА	Шинжлэх ухааны Академи

ЦДШ
ЭМЯ
ЭМГ

Цахилгаан дамжуулах шугам
Эрүүл мэндийн яам
Эрүүл мэндийн газар

ОРШИЛ

Орон нутгийн ээлжит сонгуулиар байгуулагдсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний бүрдүүлсэн Засаг дарга, Тамгын газар үйл ажиллагаагаа явуулаад 2 жил өнгөрч байна. Энэ хугацааны ажлын үр дүн, явцад дүгнэлт хийж үзээд аймаг орон нутгийн хөгжлийг улс төрийн сонгуулийн 4 жилийн хугацаанд хэрэгжих мөрийн хөтөлбөрөөр бус наад зах нь 10 жилийн хэтийн төлөвийг тооцсон, ирээдүйг харсан хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн Засаг даргын саналыг Аймгийн Иргэдийн хурал дэмжиж Ховд аймгийг 2015 он хүртэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн төсөл боловсруулах шийдвэр гаргасан билээ.

Аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөлд дүгнэлт хийж сум, байгууллагын санал, улс төрчид, эрдэмтэд судлаачдын, зөвлөмжид тулгуурлан "Ховд аймгийн хөгжлийн хөтөлбөр"-ийн төслийг боловсруулав.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл), Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Монгол Улсын Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр болон шинэ тогтолцоонд шилжиж эхэлсэн үеэс өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар нь Ховд аймгийн хөгжлийн энэхүү хөтөлбөрт тусгалаа олсон бөгөөд уг хөтөлбөрийг боловсруулах үзэл баримтлалын үндэс болсон юм.

Ховд аймагт 2005 оны байдлаар 91,7 мянган хүн оршин сууж байгаа нь улсын нийт хүн амын 3.6 хувьтай тэнцэж байна. 2005 оны байдлаар 1000 хүнд ногдох төрөлт 19.3, нас баралт 4.7, цэвэр өсөлт 14.6 байгаа нь 2000 оныхоос төрөлт 29.4 хувь, цэвэр өсөлт мөн 33.5 хувиар буурчээ. Шилжих хөдөлгөөн их байгаа нь хүн амын жилийн дундаж өсөлт буурах гол шалтгаан болж байна. Сүүлийн 5 жилд нийт 10,1 мянган хүн шилжин явжээ. Иймд хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулж, хүн амын өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх шаардлагатай байна. Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 4.1, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх нийт өрхийн 44.4 хувийг эзэлж байгаа нь улсын дунджаас өндөр байна. Хөдөлмөрийн насны хүн амын 34,5 хувь нь хөдөлмөр эрхлээгүй байгаа бөгөөд ажилгүйдэл дагасан ядуурал өссөн байна. Цаашид аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин шинэ ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж ядуурлыг эрс бууруулах шаардлагатай байна.

Ховд аймагт боловсрол, эрүүл мэндийн салбарын хүрээний тулгамдсан асуудлууд ч цөөнгүй байна.

Ховд аймаг нь 2005 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 1.8 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр баруун бүсэд

тэргүүлж байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ оны үнээр 2004 онд 370.2 мянган төгрөг байсан бол 2005 онд 501.0 мянган төгрөг болж өссөн байна.

Эдийн засагт эдгээр нааштай өөрчлөлтүүд гарч байгаа боловч урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлууд цөөнгүй байна. Тухайлбал, баруун бүсийн болон Ховд аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ манай улсын бусад бүсүүд, аймгуудтай харьцуулвал бага байна. Энэ нь эдийн засгийн хөгжлийн түвшин харьцангуй доогуур байгааг харуулж байгаа юм.

Баруун бүсийн бусад аймгуудтай харьцуулбал Ховд аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин бага байна. 2005 оны байдлаар ДНБ-ний зөвхөн 7.2 хувь нь аж үйлдвэрийн салбарт ногдож байна. Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт хурдац бүхий даацтай өндөр өсөлтийг бий болгох шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар аймгийн хэмжээнд 9,4 мянган малчин өрхийн 21,5 мянган малчид ажиллаж амьдарч байна. 2005 оны эцсийн байдлаар 1963.7 мянган мал тоологдосноос тэмээ 0.8, адуу 3.9, үхэр 4.9, хонь 35.8, ямаа 54.6 хувийг тус тус эзлэж байна. Газар тариаланд 2,5 мянга орчим га талбайг ашиглаж байгаа бөгөөд ихэнхи хувийг төмс, хүнсний ногоо, нарийн ногооны тариалалт эзлэж байна. Энэ 2006 онд 20.5 мянган тн ургац хураан авсан ба жилд дунджаар нэг га–гаас 100–120 цн-ийг хураан авч байна. Үр тарианы үйлдвэрлэлийн хувьд тариалах талбай, га – гаас авч байгаа ургацын хэмжээнээс хамааран төдийлөн ахиц гаргахгүй байна.

Ховд аймагт хөрсөн зам зонхилж байна. Ховд хотд 18,4 км хатуу хучилттай болон сайжруулсан зам ашиглаж байна. Хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээнд ихэнхдээ суудлын авто машин үйлчилдэг. Аймгийн төвөөс Мянгад сум хүртэлх 40 км хатуу хучилттай замыг ашиглаж байна. Агаарын тээвэр УБ-Ховд-УБ, УБ-Ховд-Булган-Ховд-УБ-ын чиглэлд нислэг үйлдэн, нисэх буудал нь орчин үеийн авиа навигацийн тоноглолоор бүрэн хангагдаж, онгоц буух хөөрөх зурвас нь хатуу хучилттай томоохон агаарын тээврийн хөлгүүдийг хүлээн авах бололцоотой болжээ. Баруун бүсийн нутгаар дайран өнгөрөх “Мянганы зам” – ын хэвтээ тэнхлэг болон Ярант, Цагааннуурын боомтуудыг холбох босоо тэнхлэгийн замуудыг барьж эхлэх, зам гүүрийн барилгын техник, технологийг байгальд халгүй, эдийн засгийн өндөр үр ашигтай болгох, агаарын тээврийн Олон улсын үйлчилгээг нээж өргөтгөх шаардлагатай байна.

Мянгад сумыг Увс аймгийн Өмнөговь сумаас 110 квт-ийн 99.6 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар баруун бүсийн эрчим хүчний системд холбож, Ховд аймгийг импортын цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Энэ шугамаар Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад, Буянт, Дуут сумдыг байнгын цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Цаашид нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр нүүрсний орд газар ашиглах эрчим хүчний хангамжийг сайжруулах замаар Хөшөөтийн уурхайг түшиглэн коксжсон нүүрс болон байгалийн хий олборлох талаар Засгийн газар болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

Холбооны үйлчилгээнд өндөр хурдны сүлжээ тоон системийг бүрэн нэвтрүүлэх, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах, мэдээллийн технологийг айл өрхөд хүргэх, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейн шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах шаардлагатай байна. Хөшөөтийн нүүрс, Халзан Бүргэдтэйн газрын ховор элемент, Бодончийн гялтгануур, Мянгадын Шалын шавар зэрэг ашигт малтмал, эрдэс баялгийн арвин нөөц бүхий зарим орд илэрцүүд нь олборлох, боловсруулах үйлдвэрийн таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

Ховд аймагт байгаль, түүхийн сонин тогтоц, дурсгалтай газар олонтой, олон ястны өвөрмөц зан заншил, соёл нь аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтой юм.

Байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын холбогдолтой шийдвэрлэвэл зохих асуудлууд ч цөөнгүй байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөж, худаг, ус тойрсон бага хэмжээний газар олон тооны мал төвлөрч бэлчээрийн талхагдлыг ихэсгэж, нийт нутгийн хэмжээгээр бэлчээрийн даац хүрэлцэхгүй байдал ажиглагдаж байна. Модлог болон бутлаг ургамлыг зөвшөөрөлгүйгээр огтолж ашиглах явдал ихсэж аймгийн төв, суурин газрын ойролцоох бургас харганы нөөц эрс багасчээ. Элсний нүүдлийг зогсоох, цөлжилтөөс хамгаалах явдал байгаль хамгааллын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Хөгжлийн нөөц боломж, давуу талыг оновчтой ашиглах замаар технологи бүхий боловсруулах аж үйлдвэрийн салбар, орчин үеийн аялал жуулчлал, Ховд аймгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, өндөр ашигтай бүтцийг бий болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Тус аймгийн хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг томъёолохдоо аймгийн дотоод, гадаад нөхцөл байдалд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, **хөгжлийн давуу болон сул** талуудыг тодруулан харгалзан үзсэн болно.

Ховд аймгийн хөгжлийн гол стратегийн зорилго нь хүнээ эрхэмлэн дээдэлсэн, байгаль орчныхоо онцлогт нийцсэн, эдийн засагийг дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой, орчин үеийн технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгосон өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэц бүхий эдийн засагтай аймаг болоход оршино.

Ховд аймгийн хөгжлийн хэтийн төлвийг 2007-2010, 2011-2015 он гэсэн 2 үе шатаар авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна. Үүнд:

I үе шат (2007-2010 он)-ны эцэст эдийн засгийн даац бүхий тогтвортой өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэж ДНБ жилд дунджаар 18,0 хувиас доошгүйгээр өсөхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл өргөжиж, аймгийн эдийн засагт аж үйлдвэр, аялал жуулчлалын салбар зохих байр суурийг эзлэж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулагдан, мэдлэг, мэдээллийн технологид суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдана. Аймгийн төв орчмын бүс, сумдад мах, сүү, хүнсний ногооны чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуйнууд, мал амьтны гаралтай түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүд байгуулагдаж, хүн амын хүнсний хангамж сайжирна. Аймгийн хүн амын, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо болон ажилгүйдлийн түвшин 2006 оны түвшингээс 2 хувиар буурна. Боловсролын тогтолцоо шинэчлэгдэж, сургалтын чанар, материаллаг бааз, менежмент сайжирч, ерөнхий боловсролын сургуулиуд 11 жилийн тогтолцоонд бүрэн шилжиж, 12 жилийн тогтолцоонд шилжиж эхлэнэ. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа боловсронгуй болж, оношлогоо, эмчилгээний чадавхи сайжран, үйлчлүүлэгчдэд ээлтэй үйлчилгээний таатай орчин бүрдэж, хүртээмж, чанар нь сайжирна.

Аймгийн зам тээвэр, эрчим хүчний, сүлжээ оновчтой өргөжиж, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг бүрэн хангах үндэс суурь тавигдана. Хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн талхагдал багасаж, хог хаягдлын менежмент боловсронгуй болно. Газар хөдлөл, гал түймэр, усны үер, мал амьтны гоц халдварт өвчин зэрэг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил сайжирч, аюулд өртсөн тохиолдолд хохирлыг харьцангуй богино хугацаанд арилгах чадавхи бүрдэнэ.

II үе шат (2011-2015 он)-ны эцэст аймгийн ДНБ-ний жилийн дундаж өсөлт 20,0 хувиас доошгүйгээр тогтвортой өсч, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс нэмэгдэж, аймгийн эдийн засгийн бүтэц сайжирч, орчин үеийн **аж үйлдвэр** -

үйлчилгээ - хөдөө аж ахуй гэсэн загварт бүрэн шилжиж, эдийн засгийн салбарын бүтэц улам боловсронгуй болно. Энэ үе шатанд хүн амын ядуурал, ажилгүйдэл буурсан байна. Мөн ус, хөрсний бохирдол, эвдрэл, бэлчээрийн талхагдал эрс буурч хүн ам төрж өссөн нутагтаа ая тухтай амьдрах таатай орчин бүрдэнэ.

Ховд аймгийн хөгжлийн хөтөлбөр нь

- 1) Эдийн засгийн хөгжил;
- 2) Нийгмийн хөгжил;
- 3) Байгалийн нөөц, байгаль орчны хамгааллын хөгжил;
- 4) Хүн амын нутагшилт, хот байгуулалтын хөгжил;


5) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг арга хэрэгсэл гэсэн өөр хоорондоо нягт уялдсан 5 бүлгээс бүрдэж байгаа болно. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийн хувьд нарийвчлан тодорхойлох, мөн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг тогтмол хийж байх зорилгоор “Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ”, “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” гэсэн тус аймгийн макро үзүүлэлтийн прогноз, ДНБ-ий динамик прогноз, шаардагдах хөрөнгө оруулалтын урьдчилсан төсөөллийг хавсралтаар оруулав.

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

1.1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, салбарын зохистой бүтцийг бий болгох бодлого


Үндэслэл: Ховд аймаг нь 2005 оны байдлаар Монгол Улсын ДНБ-ний 1.8 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр Баруун бүсэд тэргүүлж байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ оны үнээр 2004 онд 370.2 мянган төгрөг байсан бол 2005 онд 501.0 мянган төгрөг болж өссөн (Зураг 1) байна.

Зураг 1




Аймгийн ДНБ-ний өсөлт оны үнээр 2003 онд 10.1 хувиар, 2004 онд 37.8 хувиар, 2005 онд 35.5 хувиар тус тус өссөн байна (Зураг 2).

Зураг 2




Эдийн засагт дээр дурьдсан нааштай өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлууд цөөнгүй байна. Тухайлбал, баруун бүсийн болон Ховд аймгийн нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ манай улсын бусад бүсүүд, аймгуудынхаас харьцангуй бага байна (Зураг 3). Энэ нь эдийн засгийн хөгжлийн түвшин харьцангуй доогуур байгааг харуулна. .

Зураг 3




Манай улсын ДНБ-ний салбарын бүтцийг 2005 оны байдлаар үндсэн 3 салбараар авч үзвэл хөдөө аж ахуй 19.7 хувийг, аж үйлдвэр, барилга 35.5 хувийг, үйлчилгээ 44.8 хувийг тус тус эзлэж байхад Ховд аймагт 76.0, 7.2, 16.9 байгаа нь эдийн засгийн салбарын хөгжлийн харьцаа ихээхэн хоцрогдож байгааг (Зураг 4) илтгэнэ.

Зураг 4



Энэ үзүүлэлтээрээ баруун бүсийн бусад аймгуудтай харьцуулахад ч хоцрогдонгүй байна (Зураг 5). Энэ нь Ховд аймгийн эдийн засагт бэлчээрийн мал аж ахуйд суурилсан ХАА голлох үүрэгтэй байгаагаас шалтгаалж байна.

Зураг 5



Аймаг 2006 онд орон нутгийн төсөвт 1194.1 сая, улсын төсөвт 700.6 сая төгрөгийн, нийт 1894.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлнэ. Энэ нь орон нутгийн төсвийн зарлагын 69 хувийг, улсын төсвийн байгууллагуудын нийт зарлагын 8.2 хувийг аймаг өөрөө бүрдүүлж байгаа хэрэг юм. Энэ бол чамлалтай үзүүлэлт юм. Аймагт 3,5 мянган төрийн албан хаагчидтай төсвийн 185 байгууллага ажиллаж байгаа бөгөөд 10.7 тэрбум төгрөгийн зардал гардаг нь дотоодын нийт бүтээгдэхүүний 23.8 хувийг эзэлж, улсаас татаас авч хараат байдалд байна.

Өнөөгийн байдлаар аж үйлдвэр сул хөгжсөн, эдийн засгийн бүтэц оновчтой бус, хөгжлийн хурдац удаан байна.

Иймд бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засгийн салбарын бүтцийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн эдийн засгийн салбарын бүтцийг шинэчлэн, ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг 18-аас доошгүй хувьд хүргэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эрдэс түүхий эдийн нөөцийн хайгуул судалгааг эрчимжүүлж, ашиглах үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх;
- Шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах;
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих Засгийн газрын хөтөлбөрийг аймгийн хэмжээнд шуурхай хэрэгжүүлэх ажлын хүрээнд эн түрүүнд мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг эрчимтэй хөгжүүлэх;
- Албан бус секторын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг аймгийн ДНБ-ийн тооцоонд бүрэн хамруулах;
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах;
- Эрчим хүч, автозам, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээг хөгжүүлэх хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө бүхий салбар болгох;
- Аймгийн төвд Технологи дамжуулах төв байгуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Хилийн гарц, боомтуудын үйл ажиллагааг улам сайжруулж, гадаад харилцааны таатай нөхцөлийг бүрдүүлэх.
- Хүн амын хоол хүнс, өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг өргөтгөн хөгжүүлэх;
- Уул уурхайн аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэх зорилгоор дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад зориулан эдийн засаг, эрх зүйн илүү таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах;
- Аймгийн нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх, экспортлох зорилгоор “Нүүрс” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Хөгжлийн энэхүү хөтөлбөртэй нягт уялдуулан төсөв боловсруулж, хэрэгжүүлдэг журамд бүрэн шилжих;
- Ховд аймгийн хөгжлийг дэмжих сан байгуулж, банк, санхүүгийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх;

Гарах үр дүн: Аймгийн эдийн засагт аж үйлдвэр, үйлчилгээний салбар тэргүүлэх байр сууртай болох үндэс суурь тавигдана.

Тэргүүлэх зорилт 2. Аймгийн ДНБ-ний үйлдвэрлэлд аж үйлдвэрийн салбарын хувийн жинг 27.5 хувьд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эдийн засгийн өндөр үр ашигтай эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийг шинээр байгуулах;
- Ховд хотод үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж хөгжүүлэх;
- Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэсэн боловсруулах үйлдвэрлэл болон аялал жуулчлалын салбарт гадаадын зээл тусламжийг түлхүү хуваарилуулан ашиглах талаар төр, засгийн газартай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах;

- Аймагт барилгын материалын үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гааль болон нэмүү өртгийн татвараас чөлөөлүүлэх, хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авах;

Гарах үр дүн: Аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбар давамгайлах үүрэг гүйцэтгэх болно.

Тэргүүлэх зорилт 3: Төсвийн урсгал зардлын бүтцийг оновчтой болгож аймгийн төсвийн зарлагын зохистой харьцааг хангаж, улсаас авах санхүүгийн дэмжлэгийг багасгаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжих.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Төсвийн захирагч, менежер нарын санхүү, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх;
- Төсвийн төлөвлөлтийг сайжруулж, үргүй зардлыг бууруулах.
- Бүх сумдыг төрийн сангийн нэгдсэн сүлжээнд холбож төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах;
- Татварын бааз суурийг өргөтгөх, татвар хураах үйл ажиллагааг сайжруулах замаар орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх;
- Төвлөрлийг сааруулж орон нутгийн санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: Аймаг бие даан хөгжих нөхцөл бүрдэж нийт зардлын 90 хувийг орлогоороо бүрдүүлж, аймгийн ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хэмжээ 23 хувиас хэтрэхгүй болсон байна.

Тэргүүлэх зорилт 4: Аймагт банк санхүүгийн үйлчилгээний оновчтой тогтолцоог бий болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Банкны Үйл ажиллагааг орон нутагт хөрөнгө оруулах, аймгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр дэмжих;
- Банкны байгууллагатай өрсөлдөхүйц орон нутгийн шинж чанартай санхүүгийн байгууллагуудыг бий болгох;
- Одоо байгаа банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг хямдруулж, хөрөнгө оруулах, хүн амын амжиргааг дээшлүүлэх чиглэлээр хөнгөлөлттэй үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлэх;
- Бүс нутгийн шинж чанартай гадаад болон дотоод төлбөр тооцоо, санхүүгийн болон түрээс, авлага барагдуулах зэргээр үйл ажиллагаа явуулах бичил санхүүгийн байгууллагуудыг байгуулж ажиллуулах, үр ашигтай ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;

Гарах үр дүн: Орон нутгийн хүн амын эрх ашигт нийцсэн, аймагт хөгжил авчрах санхүүгийн чадварлаг, шударга өрсөлдөөнт бүтэц бий болно

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 20 хувиас доошгүй тогтвортой байлгах нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- **Аймгийн онцлогт нийцсэн бизнесийн орчинг сайжруулах;**
- Үйлдвэрлэл, технологийн паркуудаар дамжуулан дэвшилтэт техник, технологийг тууштай нэвтрүүлэх;
- Эрдэс баялгийн орд газруудад түшиглэсэн ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйлдвэрүүдэд бүх талын дэмжлэг үзүүлж, зарим үйлдвэрүүдийг шинээр нэмж байгуулах;
- МАА, газар тариалангийн түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, экологийн цэвэр бүтээгдэхүүний экспортыг эрс нэмэгдүүлэх;

- Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн нэг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх.
- Аймгийн хөгжлийн арилжааны банк байгуулан ажиллуулж эхлэх;
- Статистикийн албан ёсны мэдээллийг өрх , иргэн аж ахуйн нэгж бүрээр авч мэдээлэлийн үнэн зөв бодит байдлыг сайжруулах, Татварын хэлтсийг дэвшилтэт техник технологи бүхий төнөг төхөөрөмжөөр ханган, материалаг баазыг бэхжүүлэх;
- Төсвийн захирагч, менежер нарын санхүүгийн хууль эрх зүйн мэдлэгийг байнга дээшлүүлэх;
- Төсвийн төлөвлөлтийг сайжруулж, үргүй зардлыг бууруулах;
- Сумдын төсөвт байгууллагуудыг төрийн сангийн нэгдсэн сүлжээнд бүрэн холбож төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах;
- Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоог жинхэнэ утгаар нь ажиллуулж тэдний санхүүгийн үйлчилгээг банкны байгууллагатай өрсөлдөхүйц хэмжээнд хүргэхэд дэмжлэг үзүүлэх;
- Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг банкны байгууллагатай өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх;

Гарах үр дүн: Аймгийн ДНБ-ний бодит өсөлт тогтворжиж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь бий болно.

Тэргүүлэх зорилт 2. Аймгийн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 20 хувьд хүргэж, эдийн засгийн салбарын бүтцийг улам боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг гүнзгийрүүлж олборлох, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарт тулгуурлан аймаг бие даан хөгжих нөхцлийг бүрдүүлэх;
- Нүүрс, хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;
- Хүн амын хүнс, өргөн хэрэглээний бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг өргөтгөн хөгжүүлэх;
- Даатгалын үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөж, нэр төрлийг олшруулан, ялангуяа байгаль, цаг уурын эрсдэл ихтэй мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг даатгалд бүрэн хамруулах;
- Барилгын материалын үйлдвэрлэлээр бүсийн хэрэгцээг бүрэн хангадаг болох;

Гарах үр дүн: Аймгийн эдийн засагийн БҮТцэд аж үйлдвэр, үйлчилгээний салбар тэргүүлэх байр суурьтай болж, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрс нэмэгдэнэ.

1.2. Аж үйлдвэрийн хөгжил

Үндэслэл: 2005 оны байдлаар ДНБ-ний зөвхөн 7.2 хувь нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байгаа нь Баруун бүсийн бусад аймгуудтай харьцуулбал Ховд аймгийн эдийн засагт энэ салбарын эзлэх хувийн жин бага байна. Өнөөгийн байдлаар Ховд аймагт эсгий, эсгий гутлын үйлдвэр 2, мах косеревны, цэвэр усны, өлөн гэдэс боловсруулах, тоосгоны зэрэг 20–иод дунд, жижиг үйлдвэр, барилгын материал, талх нарийн боов, хиама, зайрмаг, ундаа, авто машин болон гутал засвар, мужааны үйлчилгээ явуулдаг 70 гаруй аж ахуйн нэгж ажиллаж байна. Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт өндөр өсөлтийг бий болгох шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын томоохон орд газруудыг ашиглалтад оруулах замаар аймгийн ДНБ-д аж Үйлдвэр, уул уурхайн салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ашигт малтмалын эрэл хайгуул, зураглалын ажлын тэргүүлэх чиглэлийг тогтоож, эхний ээлжинд ашиглах боломжтой эрдэс баялгийн ордыг ашиглах; аймгийн нутаг дэвсгэрийн 50 хувийг хайгуулын 1:50000 зурагтай болгох
- Шинээр байгуулагдах уул уурхайн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг хил залгаа орнуудад экспортлоход түлхүү анхаарах;
- Ашигт малтмалын ордуудыг ашиглахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цогцолборыг байгуулах асуудлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхэд анхаарах;
- Ховд аймагт барилгын материалын (цемент, тоосго ,шохой зэрэг) үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх;
- Аймгийн эрдэс баялгийн нөөцөд тулгуурлан бүсийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтцийг шинэчлэн өөрчлөх мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- Нөөц нь тогтоогдсон Хөшөөтийн нүүрсний уурхайд коксын болон хийн үйлдвэр байгуулж, эцсийн бүтээгдхүүн боловсруулан экспортлох.
- Хөшөөт, Байтагийн чиглэлт авто болон төмөр зам тавих.
- Дөргөний УЦС,-Мйстийн УЦС-ыг ашиглалтанд оруулж, бүх сумдыг эрчим хүчний байнгын эх үүсвэртэй болгох.
- Аймгийн төвд ойрхон байрлалтай нүүрсний орд газрын /Манхан сумын Ганц мод, Дарви сумын Өлзийт, Чандмань сумын Бараан шороот, Дөргөн сумын Мантаг/ хайгуул хийж олборлолтыг эхлүүлэх.
- Шахмал түлшний үйлдвэр байгуулах;
- Нүүрсний нөөцийн хайгуул хийх, Олон булгийн нүүрсний уурхайн ашиглалтыг сайжруулж, баруун 3 сумын нүүрсний хэрэгцээг хангах;

Гарах үр дүн: Уул уурхайн үйлдвэрлэлийн хурдацтай өсөлтийн үр дүнд аймгийн ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувийн жин өснө.

Тэргүүлэх зорилт 2. Аймгийн аж үйлдвэрийн салбарт боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай импортоор оруулах техник, тоног төхөөрөмж үндсэн болон туслах материал гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх саналыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;
- Аймгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих “Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан” байгуулж ажиллуулах;
- Сангийн яам, Монгол Банк, арилжааны банкуудтай хамтран ажиллаж жижиг, дунд үйлдвэрт зориулан бага хүүтэй, урт хугацааны арилжааны зээлийн эх үүсвэрийг бий болгох, нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Улсын болон орон нутгийн захиалгаар санхүүжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хамруулах бодлого баримтлах;
- Ховд хотод холимог үйлдвэрлэлийн “Ховд” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах;
- Орон нутгийн туршлагыг харгалзан аймгийн төв болон сумдад эсгий, эсгий гутал, ноос угаах төрөлжсөн болон хоршсон үйлдвэрлэлийг өргөтгөн хөгжүүлэх;

- Сүү, сүүн бүтээгдэхүүний болон мах боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, төрөлжүүлэн савласан мах, махан ба сүүн бүтээгдэхүүн экспортлохыг дэмжих;
- Малын арьс, шир, ноос ноолуур зэрэг түүхий эдийг боловсруулж гутал, дээл, нэхий эдлэл, эсгий, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг, дунд үйлдвэрүүдийг шинээр байгуулахыг дэмжих;
- Бөөний худалдааны сүлжээг оновчтой бий болгон, энэ сүлжээнд хамрагдах сум, аж ахуйн нэгж, иргэдийн тоог нэмэгдүүлэх;
- “Нэг суурин-нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг өрнүүлэх;
- Ярантын боомтыг түшиглүүлэн худалдааны чөлөөт бүс байгуулах;
- Ховд хотын орчимд үр тариа, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн боловсруулах төв, Буянт суманд жимс, жимсгэнэ, хүнсний ногооны болон экологийн цэвэр бүтээгдэхүүний жижиг үйлдвэр байгуулах;

Гарах үр дүн: Боловсруулах аж үйлдвэр тогтвортой өсч, экспортын бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээ эрс нэмэгдэнэ.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 18 хувьд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мянгадын Халзан Бүргэтэйн ховор металлын ордыг ашиглалтад оруулах;
- Уул уурхайн үйлдвэрлэлийн жигд тогтвортой өсөлтийг хангах;
- Ховд аймгийн Олон булгийн нүүрсний уурхайн төслийн хүчин чадлыг бүрэн, Булган, үенч, Алтай сумын нүүрсний хэрэгцээг хангах;
- Махны үйлдвэрлэлтэй уялдуулан арьс ширийг стандартын дагуу ангилан бэлтгэх, энэ үндсэн дээр арьс, ширэн болон савхин эдлэл, гутал, хувцас, тоноглол хэрэглэлийн үйлдвэрлэлийг өргөтгөн хөгжүүлэх;
- Ноос, ноолууранд анхан шатны болон гүнзгийрүүлсэн боловсруулалт хийж, дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ экспортын баримжаатай үйлдвэрүүдийг хөгжүүлэх;
- Алтны уурхайнуудад хайгуул хийлгэн ашиглуулах арга хэмжээ авах (Мянгад сумын Цагаан толгой, Дуут сум Цагаан бургас, Буянт сумын Билүүт, Булган сумын Цоохорын нурууны булагт хар, Үенч сумын Ганц мод, Багсармал, холимог, хорголжин болон бичил язгуур махбодын бүрэн найрлагат эрдсийн тэжээлийн үйлдвэр байгуулж, төрөл бүрийн тэжээл үйлдвэрлэх;
- Хүнсний үйлдвэрийн чиглэлээр хүнсний ногоог дахин боловсруулах, үр тариа, жимс, жимсгэнэ, тариалалтыг нэмэгдүүлж, гурил болон бусад үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээгээ хангах;
- Ингэний ундаа, рашаан савлах, цөцгийн тосны үйлдвэр байгуулан, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, тоо хэмжээг нэмэгдүүлэх, гадаад дотоодын зах зээлд гаргах;

Гарах үр дүн: Аймгийн эдийн засагт аж үйлдвэрийн салбар тэргүүлэх байр суурийг эзэлнэ.

1.3. Хөдөө аж ахуйн хөгжил

Үндэслэл: Өнөөгийн байдлаар байгалиас хараат бэлчээрийн МАА-д суурилсан ХАА аймгийн эдийн засагт голлох үүргийг гүйцэтгэж байна.

Өнөөгийн байдлаар аймгийн хэмжээнд 9356 малчин өрхийн 21461 малчид ажиллаж амьдарч байна. Малын тоо толгойг төрлөөр нь авч үзвэл 2005 оны эцсийн

байдлаар 1963.7 мянган мал тоологдсоноос тэмээ 0.8, адуу 3.9, үхэр 4.9, хонь 35.8, ямаа 54.6 хувийг тус тус эзлэж байна.

Газар тариаланд 2500 орчим га талбайг ашиглаж байгаа бөгөөд ихэнхи хувийг төмс, хүнсний ногоо, нарийн ногооны тариалалт эзлэж байна. Жилд хурааж авах ургацын хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэж 2006 онд 20,5 мянган тн ургац хурааж авсан ба га-гаас дунджаар 100-120 цн ургац хурааж байна.

Мах-ноосны чиглэлийн Сутай омгийн хонь, мах өөхний чиглэлийн Торгууд үүлдрийн хэсгийн хонь, ноолуурын чиглэлийн Алтайн улаан үүлдрийн хэсгийн ямааг нутгийн үүлдрийн малд сайжруулагчаар ашиглаж байна.

Мал эмнэлэг, үржлийн нэгжийн үйлчилгээг хувийн хэвшлийн мал эмнэлэг-үржлийн нэгжүүд үзүүлж байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд жилд 1.3 сая мал, паразит өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 1.2 сая, лабораторийн шинжилгээ, оношлогоонд 21.0 мянган мал хамрагдаж нийт 222 сая төгрөгний эм бэлдмэл зарцуулж байна.

Бэлчээрийн усан хангамж уулархаг, говийн бүсийн сумдад муутай, өнгөрсөн жилүүдэд улсын төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 100 орчим худгийг сэргээн засварласан ч, зайлшгүй шинээр гаргах, засварлах шаардлагатай худгууд үлдээд байна.

Иймд аймгийн ХАА-н салбарыг эрчимжүүлж, энэ салбарын хөгжилд чанарын йрчлйлт гаргах шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн мал аж ахуйн салбарыг тогтвортой хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бэлчээрийн мал маллагаанд нутгийн үүлдрийн малыг өөр дотор нь шилж сонгон цэвэр үржүүлгийн аргыг хэрэглэхээс гадна нутгийн үүлдэр, омгийн малаар сайжруулах ажлыг хослон хэрэгжүүлэх;
- Өндөр уулын сумдад сарлагийг, сүү тосны чиглэлээр цэвэр үржүүлгийн аргаар өсгөх;
- Хүн амын сүү, махны хэрэгцээнд зориулан сүүний үүлдрийн ямааны гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэх туршилтын ажлыг хэрэгжүүлэх;
- Мал сүргийг байнгийн даатгалд хамруулах ган, зудын хохирлоос сэргийлэх ажлыг зохион байгуулах;
- Мал сүргийг хулгайлах гэмт хэргийг эрс багасгах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
- Төв, суурин газрын ойролцоо нутгийн үхэр, сарлагийг мах, сүүний чиглэлээр, ямааг сүүний чиглэлээр сонгон үржүүлэх эрчимжсэн фермерийн болон хагас суурин аж ахуй байгуулж эрхлэхийг дэмжих;
- Бөөний худалдааны сүлжээнд түшиглэн түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох;
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн гол асуудлуудаар мэргэшсэн туршлагатай хүмүүсээс бүрдсэн ажлын хэсгийг ажиллуулан энэ салбарын хөгжлийн чиг хандлагын талаар байнга үнэлэлт дүгнэлт гаргуулж байх;

Гарах үр дүн: Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, малчдын ашиг орлого нэмэгдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Аймгийн онцлогт нийцүүлэн бэлчээр ашиглалтын менежментийг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг өсгөн үржүүлэх бодлого хэрэгжүүлэх;
- Аймгийн бэлчээрийн менежментийн зураг гаргуулж мөрдөх;
- Бэлчээрийг хуваарьтай ашигладаг уламжлалт аргыг сэргээн сум, багийн түвшинд бэлчээр ашиглалтыг сайжруулах;
- Өндөр уулын бүсэнд царцаатай тэмцэх ажлыг эрчимжүүлж, үр дүнд хүргэх.
- Тусгай хамгаалалтын газрын орчинд нутаглаж буй малчдад бэлчээрийн газар ашиглах урт хугацааны гэрээ байгуулах боломж бүрдүүлэх талаар эрх зүйн зохицуулалт хийх;
- Бэлчээрийн үржил шимийг сайжруулахдаа экологийн тэнцвэр алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах;
- Малыг тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх, улмаар өндөр ашигт малыг тэжээх тэжээлийг хийх, тариалалтанд ашиглах төрөл бүрийн био бордоо үйлдвэрлэж байгаа арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх;
- Бэлчээрт ашиглагдахгүй байгаа хуучин худаг, услалтын системүүдийг сэргээн засварлах;
- Бэлчээрийг малчдын бүлэг, нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэх, даац, ургацыг тодорхойлсоны үндсэн дээр нутаг бэлчээрээ зохицуулдаг уламжлалт аргыг зааж сургах;
- Өндөр уулын бүсэд хадлангийн талбай бий болгож байгаа, болон бэлчээрийг сэргээх санаачлагыг иргэд дэмжиж туслах,
Гамшигаас хамгаалах сан байгуулах;
- Бэлчээрийн цөлжилт, талхагдалтыг үүсгэж буй хүчин зүйлүүдийг судлах, тэмцэх арга хэмжээг зохион байгуулах;

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд бэлчээрийн менежмент боловсронгуй болж бэлчээрийн даац үлэмж дээшилнэ.

Тэргүүлэх зорилт 3. Мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хөдөө аж ахуйн хоршоо, фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Төрийн зохицуулалтын хөшүүргүүдийг хэрэглэн хоршоо, фермерийн аж ахуйг дэмжих;
- Үйлчилгээ, борлуулалт, хангамжийн хоршоодын үйл ажиллагааг дэмжих;
- Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийг дэмжих;
- Сүүн болон махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн дээр фермерийн эрчимжсэн загвар аж ахуй байгуулах үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжих;
- Хот суурин газрын ойролцоо гахай, тахиа, зөгийн туслах аж ахуй бий болгох санаачлагыг дэмжиж туслах;

Гарах үр дүн: Мал аж ахуй дахь хөдөлмөр зохион байгуулалт сайжирч, фермерийн загвар аж ахуйнууд бий болно.

Тэргүүлэх зорилт 4. Мал, амьтныг эрүүлжүүлэх ажлыг сайжруулж, гоц халдварт өвчинтэй тэмцэх арга механизмыг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, нян судлал, ийлдэс судлал, ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг боловсронгуй болгож, мал эмнэлгийн лабораторыг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах;
- Улсын хилийн боомтуудад мал эмнэлгийн хорио цээрийн найдвартай хамгаалалт бий болгож, мал амьтны халдварт өвчин, ялангуяа гоц халдварт өвчин улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх, нэвтрэн орж ирсэн нөхцөлд тэдгээртэй тэмцэх арга

хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүх шатанд сайжруулж, мал эмнэлгийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлийн хангамжийг сайжруулах;

- Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх замаар өрсөлдөөнийг бий болгож, чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авах;
- Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн материаллаг бааз, эмийн нөөц хангамжийг сайжруулах, боловсон хүчнийг чадавхижуулах;
- Аймгийн мал эмнэлгийн шинжилгээний лабораторийн материаллэг бааз тоног төхөөрөмжийн хангамж, хүрэлцээ, оношлогооны чадавхийг дээшлүүлэх;
- Орон нутгийн чанартай гардаг оношлогдоогүй өвчнийг оношлох, эмчлэх шинжилгээ судалгааны ажлын арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх;
- Үржлийн шилмэл хээлтэгч, хээлтүүлэгч мал бойжуулж бэлтгэн нийлүүлэх;
- Шилмэл малын бүртгэл мэдээллийн санг баяжуулж, үзэсгэлэн худалдааг бүс, аймаг, сумын түвшинд зохион байгуулах;
- Өндөр ашиг шимт сайн чанарын үрээр зохиомол хээлтүүлгийн ажлыг явуулж, нутгийн байгаль цаг уурт дасан зохицсон цөм сүргийг бий болгох;

Гарах үр дүн: Мал эрүүлжиж, гоц халдварт өвчний гаралт, сөрөг нөлөөлөл эрс буурна.

Тэргүүлэх зорилт 5. Газар тариалангийн үйлдвэрлэлийг жилд 7 хувиас доошгүй тогтвортой өсгөх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн газар тариаланг хөгжүүлэх дунд (2-5 жилийн) хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах;
- Газар тариалангийн үйлдвэрлэлийн эрсдлийг бууруулан нийт эргэлтийн талбайн хэмжээг 1990 оны түвшингийн 80 хувьд, 1 га-гаас авах ургацын хэмжээг улсын дунджид хүргэх;
- Буянт, Ховд, Булган голын сав дагуу үр тариа, хүнсний ногоо тариалалтыг эрчимжүүлж, Баруун бүсийн газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төв болгох;
- Усалгаатай газар тариалан, хүлэмжийн аж ахуйг бүх талаар дэмжиж, техник, тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр олгож байх арга хэмжээ авах;
- Мал аж ахуй, газар тариаланг хослон эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид бага оврын трактор, цахилгаан үүсгүүр, хадлангийн болон газар тариалангийн техник хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх арга хэмжээ авах;
- Газар тариалангийн техник, технологийг шинэчлэх, таримлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, хүлэмжийн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Газар тариалангийн иж бүрэн механикжсан загвар аж ахуй байгуулахыг бүх талаар дэмжих;
- Үр тариа, чацаргана, жимс жимсгэнэ, тарвас, хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлж, хүнсний ногоо, жимс жимсгэнийг нөөшлөх үйлдвэр байгуулан, сайн чанарын дарс, жимсний ундаа үйлдвэрлэн аймгийн болон Баруун бүсийн хэрэгцээг хангах;
- Тариаланчдын дунд үзүүлэх сургууль, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, сайн чанарын үр суулгацаар хангах, үр үржүүлж буй аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлэх;
- Газар тариалан эрхлэгчдэд газрыг урт хугацаагаар түрээсээр эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах замаар газрыг зах зээлийн эргэлтэнд оруулах ажлыг эрчимжүүлэх;
- Усалгаатай газар тариаланг хөгжүүлэх чиглэлээр зарим сумдад тариалангийн талбайд усалгааны төхөөрөмжийг шинээр болон шинэчлэн суурилуулах арга хэмжээ авах;

- Багсармал, холимог, хорголжин болон бичил язгуур махбодын бүрэн найрлагат эрдсийн тэжээлийн үйлдвэр байгуулж, төрөл бүрийн тэжээл үйлдвэрлэж байсан уламжлалыг тусгайлсан бодлогоор бүс нутагт сэргээх;

Гарах үр дүн: Газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой өсч, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн ХАА-н салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 8 хувьд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Малчдын үйлдвэрлэл, борлуулалт, фермерийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих;
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээллийн оновчтой тогтолцоог бий болгох;
- Бэлчээр ашиглалтын менежментийг улам боловсронгуй болгох;
- Төв суурин газарын дэргэд мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрчимжсэн фермерийн болон хагас суурин аж ахуйг олноор байгуулж ажиллуулах
- Махны чиглэлийн үүлдэр, омог, гойд ашиг шимтэй малыг биотехнологийн аргаар үржүүлэхэд онцгойлон анхаарахын зэрэгцээ ямааны ба адууны мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх хувилбарыг судлан хэрэгжүүлэх;
- Малын тэжээл үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Ган, зудаас хамгаалах тэжээлийн нөөцийг бий болгож, улмаар өвс тэжээл экспортлох нөхцлийг бүрдүүлэх;
- Байгалийн гэнэтийн аюулаас сэргийлэх, хохирлыг бууруулах зорилгоор малыг даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;
- Газар тариаланд орчин үеийн техник технологийг өргөнөөр нэвтрүүлж, га-аас авах ургацын хэмжээг тогтвортой нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх;
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;
- Махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр хэрэгцээнийхээ 80 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний 70 %, гурил гурилан бүтээгдэхүүний 60 % - ийг хангах;
- Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг олгох, мэдээлэл түгээх, дамжуулах, шинэ технологи эзэмшүүлэх, зуучлах үүрэг бүхий хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээг төрийн байгууллагын эрх зүйн орчинд байгуулах;
- Сумын мал эмнэлгүүдийн лабораторийн материаллаг бааз, багаж тоног төхөөрмжийн хангамж, оношлогооны чадавхийг сайжруулах;
- Хүн амын сүү, махны хэрэгцээнд зориулан сүүний үүлдрийн ямааны гүн хөлдөөсөн үрээр хээлтүүлэх туршилтын ажлыг хэрэгжүүлэх;

Гарах үр дүн: Хот суурин газрын орчим эрчимжсэн фермерийн аж ахуйн тогтолцоо бий болж, тариаланчид, малчдын амьдрал ахуй, хөдөлмөр зохион байгуулалтанд чанарын дэвшил гарна. Мал, тариалангийн бүтээгдэхүүний 50 хувийг боловсруулж үйлдвэрлэдэг болгоно.

Тэргүүлэх зорилт 2. Аймаг сумдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бэлчээр ашиглалтын түвшинг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүх төрлийн худаг засварлах, барих ажлыг гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжих;
- Сум бүрт үерийн хөв, далан байгуулах ажлыг эрчимжүүлж, бэлчээр усжуулалтын түвшинг дээшлүүлэх;

- Эдийн засгийн урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэн бэлчээрт худаг гарган ашиглах үүсгэл санаачлагыг тууштай дэмжих;
- Бэлчээр усжуулах ажилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах оновчтой арга механизмыг нэвтрүүлэх;
- Бэлчээрийн эрсдлийн болон гамшигийн менежментэд малчид, тариаланчид, жижиг үйлдвэрлэл эрхлэхлэгчдийг сурган дадлагажуулах;
- Инженерийн хийцтэй услалтын системийг засварлах, уст цэгийн хайгуул, худаг шинээр гаргах;
- Мал сүргийг индексжүүлсэн даатгалд бүрэн хамруулах;
- Аймаг, сум дундын отрын бүс нутагтай болох, аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх;
- Дотоодод үйлдвэрлэж ашиглаж байгаа төрөл бүрийн биобордоо, багсармал болон гумин, борзонгийн бордооны хангалт, хэрэглээг нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: Бэлчээрийн усан хангамжийн түвшин дээшилж, мал сүргийг өсгөн үржүүлэх таатай нөхцөл бүрдэнэ.

1.4. Дэд бүтцийн хөгжил

1.4.1. Зам тээврийн хөгжил

Үндэслэл: Ховд аймагт хөрсөн зам зонхилж байна. Ховд хот 18,4 км хатуу хучилттай болон сайжруулсан зам ашиглаж байна. Хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээнд суудлын авто машин үйлчилж байна.

Аймгийн төвөөс Мянгад сум хүртэлх 45 км хатуу хучилттай замыг ашиглаж байна. Мянганы замын хэвтээ чиглэлд Хонгио, Шургийн голын бетон гүүрээр, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын эхлэл болох БНХАУ-ын хилээс Булган сум хүртэлх 65 км хатуу хучилттай замаар тус тус холбогдож байна.

Агаарын тээвэр Ховд -УБ, Ховд-УБ-Булган-Ховд-УБ-ын чиглэлд нислэг үйлдэн, орчин үеийн авиа навигацийн тоноглолоор хангагдсан, онгоц буух хөөрөх зурвас нь хатуу хучилттай томоохон агаарын тээврийн хөлгүүдийг хүлээн авах бололцоотой.

Баруун бүсийн нутгаар дайран өнгөрөх “Мянганы зам” – ын хэвтээ тэнхлэг болон Ярант, Цагааннуурын боомтуудыг холбох босоо тэнхлэгийн замуудыг барьж эхлэх, зам гүүрийн барилгын техник, технологийг байгальд халгүй, эдийн засгийн өндөр үр ашигтай болгох, агаарын тээврийн Олон улсын үйлчилгээг нээж өргөтгөх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Мянганы зам” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Ховд аймагт ногдох хэсгийн дийлэнх хувийг барьж дуусгах;
- Цагааннуур – Өлгий - Ховд, Боршоо – Улаангом - Ховд, Ховд - Ярантай чиглэлээр гадаад худалдаа-тээврийн цогцолборуудыг байгуулж олон улсын хамтын ажиллагааны бүс нутгийн сүлжээнд хамруулах;
- Булган-Ховд-Өлгий-Цагааннуур, Ховд-Улаангом-Хандгайт чиглэлийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай автозамыг барьж эхлэх;
- Улиастай-Ховд, Алтай-Ховд хоорондох автозамыг сайжруулах;
- Аймгийн автозамын хөгжлийн хөтөлбөр боловсруулж, Азийн хөгжлийн Банкны техник туслалцаагаар шинээр боловсруулсан тээврийн стратеги болон авто зам хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх;
- Аймгийн төвийн зам, талбай, гүүрийг шинэчлэн сайжруулах;

- Төрөл бүрийн зам тавихад төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг бүх талаар урамшуулан ашиглах;
- Аймгийн авто замын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;

Гарах үр дүн: Аймгийн төрөл бүрийн замын сүлжээний хангамж эрс сайжирна.

Тэргүүлэх зорилт 2. Зам, гүүрийн барилгын техник, технологийг байгальд халгүй, эдийн засгийн өндөр үр ашиг бүхий орчин үеийн шилдэг загварын машин техникээр шинэчилэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн хангамжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр дэмжин сайжруулах;
- Экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөлөл багатай зам барилгын техник хэрэгслийн импортыг татварын бодлогоор дэмжин урамшуулах;

Гарах үр дүн: Аймгийн хэмжээний зам барилгын байгууллагуудын чадавхи, бүтээмж, ашигт ажиллагаа сайжирсан байна.

Тэргүүлэх зорилт 3. Агаарын тээврийн үйлчилгээг өргөтгөн сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Агаарын тээврийн үйлчилгээний хүртээмж, тогтвортой, найдвартай байдал, ая тухыг бүрдүүлэхэд чиглүүлэн менежментийг сайжруулах;
- Агаарын тээврийн үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог өргөтгөх;
- Нисэх буудлын барилга байгууламж, нисэх, буух зурвасыг сайжруулах;
- Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэн, БНХАУ, ОХУ-тай холбогдсон агаарын замын шугам нээх асуудлыг шийдвэрлүүлж олон улсын нислэг нээх;
- Улаанбаатараас Ховдын Булганы чиглэлд онгоц нисэх үйлчилгээг сэргээж, нисэх буух зурвасыг засч тохижуулах;

Гарах үр дүн: Агаарын тээврийн үйлчилгээний хамрах хүрээ, чанар сайжирсан байна.

Тэргүүлэх зорилт 4. Авто тээврийн үйлчилгээг аймгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн оновчтой өргөтгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төвд зорчигч үйлчилгээний төвүүдийг шинэчлэн байгуулж эхлэх;
- Аймгийн төв болон Ярант зэрэг худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс, хилийн боомтуудад ачааг хүлээн авах, сэлгэн ачих аж ахуйнуудыг байгуулах;

Гарах үр дүн: Аймгийн авто тээврийн орчин үеийн нэгдсэн сүлжээний үндсэн суурь тавигдсан байна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Мянганы замын аймгийн нутаг дэвсгэр дэх хэвтээ тэнхлэгийн хэсгийг бүрэн ашиглалтад оруулж, уул замаас салаалсан босоо тэнхлэгийн авто замын зарим хэсгийг барина.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг тавьж дуусгах;
- Мянганы замаас салбарласан зарим чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгож бүсийн бусад бүх аймагтай хатуу хучилттай замаар холбогдоно, Ховд отын бүх зам, талбайг бүрэн шинэчлэн сайжруулсан байх;

Гарах үр дүн: Аймгийн авто замын орчин үеийн нэгдсэн сүлжээ бий болно. Аймгийн нутаг дэвсгэрт 800-аас доошгүй км урт хатуу хучилттай зам тавьж, нэг хүнд ноогдох хэмжээгээр улсдаа тэргүүлэх байранд орно. Хөрш

улсууд зэргэлдээ аймгуудтай үйлдвэр, худалдаа бүх талын хамтын ажиллагаа хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Агаарын тээврийн үйлчилгээг өргөтгөн сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Агаарын тээврийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, нислэгийн аюулгүй байдлыг ханган, нислэгийн тоо, чиглэлийг үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлэн зохион байгуулах;
 - Сансрын дамжуулах станц суурилуулж нисэх буудлыг олон улсын буудал болгох;
- Гарах үр дүн:** Агаарын тээврийн үйлчилгээ шинэ шатанд гарах.

Тэргүүлэх зорилт 3. Аймгийн бүх төрлийн тээврийн үйлчилгээний оновчтой сүлжээг бий болгох.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төвд зорчигч үйлчилгээний орчин үеийн шаардлагад нийцсэн төвүүдийг ажиллуулж эхлэх;
- Ухаалаг тээврийн системийн мэдээлэл дамжуулах сүлжээ байгуулах, мэдээллийн эх сурвалжууд /шатахуун түгээх станц, техникийн засвар үйлчилгээний газар, жолооч, зорчигчийн амрах, хооллох, хоноглох буудал,...г.м./-ыг сүлжээнд холбох, тээврийн хэрэгслийн байршил, хөдөлгөөнийг тодорхойлох системийг нэвтрүүлэх;

Гарах үр дүн: Тээврийн үйлчилгээний орчин үеийн сүлжээ бүрдэнэ.

1.4.2. Эрчим хүчний салбарын хөгжил

Үндэслэл: 1997 оноос эхлэн Мянгад сумыг Увс аймгийн Өмнөговь сумаас 110 кВ-ийн 99.6 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар баруун бүсийн эрчим хүчний системд холбож, Ховд аймгийг импортын цахилгаан эрчим хүчээр хангаж эхэлсэн юм. Ховд хотыг Мянгад сумаас 35 кВ-ын 39.1 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар мөн онд холбосон ба Эрдэнэбүрэн, Ховд, Мянгад, Буянт, Дуут сумдыг баруун бүсийн төвлөрсөн системээс цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Аймагт өнөөдрийн байдлаар АНУ-ын 455 кВА чадалтай катерпиллер дизель цахилгаан станц бэлтгэлд ажиллаж, Кат 35-08 маркийн 600 кВт-ын хүчин чадалтай дизель мотор нэмэгдэж байна.

Алтай, Булган, Үенч, Мөст, Цээцэг, Манхан, Зэрэг, Дарви, Чандмань, Дөргөн, Мөнххайрхан сумдад Японы 100, 60 моторууд сум тус бүрд 2 ш суурилагдсан бөгөөд оройд 4-5 цаг ажиллаж байна.

Манхан, Мөнххайрхан сумдад бага оврын УЦС дулааны улиралд ажиллаж, шинээр Үенчийн УЦС ашиглалтанд орж, Дөргөний Чоно-харайхын УЦС баригдаж байна.

Ховд хот нь төвлөрсөн дулаан хангамжийн системтэээй. Энэ нь 1986 онд ашиглалтанд орсон КЕ-25-14х2, КВТС-150-20х2 зуухтай, 4 бойлертой хүчин чадлынхаа 50%-ийг гарган ажиллаж, нүүрсээ Хар тарвагатайн уурхайгаас авдаг ба үйл ажиллагааг менежментийн хувьчлалаар хувьчлаад байна. Мөн Азийн хөгжлийн банк, Нордикийн сангийн төслийн хүрээнд Мөст, Чандмань, Булган, Мянгад сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгын халаалтын систем, зуухыг шинэчлэсэн. Аймгийн хэмжээнд түлшийг Хөшөөт, Олонбулгийн уурхайгаас тус тус хангаж байна.

Цаашид нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр нүүрсний орд газар ашиглах эрчим хүчний хангамжийг сайжруулах замаар Хөшөөтийн уурхайг түшиглэн коксжсон нүүрс болон байгалийн хий олборлох талаар Засгийн газар болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн цахилгаан ээрчим хүчний үйлчилгээний чанарыг сайжруулж хээрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ховд хотын цахилгаан шугам сүлжээг Дэлхийн банкны “Нам хүчдэлийн шугам сүлжээний алдагдал бууруулах” төсөлд хамруулж өргөтгөх;
- Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрснээс хий, дулаан, цахилгаан гаргах орчин Үеийн технологи бүхий үйлдвэр барих;
- Хөшөөтийн нүүрсний уурхайгаас Цэцэг, Мөст сумдыг эрчим хүчний шугаманд холбох;
- Үенчийн УЦС-аас Булган, Алтай сумдыг цахилгаан эрчим хүчээр хангах;
- Дөргөний усан цахилгаан станцыг ашиглалтанд оруулж, Баян-өлгий, Увс аймгийг цахилгаанаар хангах;
- Эрдэнэбүрэнгийн 80-100 МВт хүчин чадалтай УЦС-ыг барьж эхлэх.
- Мөст суманд 150 кВ-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих;
- Дөргөн-Мянгадын 110 киловольтын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг ашиглалтанд оруулан баруун гурван аймгийн зарим сумдыг төвлөрсөн системд холбох;
- Ховд хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх;
- “Цахилгаан түгээх сүлжээ” компаниудыг хувьчилж, менежментийг сайжруулан техник, технологийн шинэчлэлт хийх замаар шугамын болон зүй бус алдагдлыг эрс багасгах;
- Аймгийн бүх сумдыг эрчим хүчний байнгийн найдвартай эх үүсвэртэй болгох. Үүний тулд Манхан, Зэрэг, Чандмань, Дарви, Алтай сумдыг өндөр хүчдэлийн шугамд холбон, Говь-алтай аймагт хөшөөтийн уурхайгаас цахилгаан түгээх
- Нар, салхины сэргээгдэх эрчим хүч, бусад дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар сум, суурингуудыг, цахилгаанаар бүрэн хангах;
- “100 мянган нарны гэрэл” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж малчин өрхийг цахилгааны эх үүсгүүрээр бүрэн хангах;

Гарах үр дүн: Аймгийн эрчим хүчний систем өргөжин, эрчим хүчний хангамж жигд сайжирна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- § Эрдэнэбүрэний УЦС-ыг ашиглалтанд оруулах.
- § Аймгийн түлш, эрчим хүчний үйлдвэрүүдэд шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, тоног төхөөрөмжийг нь иж бүрэн шинэчлэх;
- § Аймгийн хэмжээнд нар, салхины эрчим хүчний нөөцийг тогтоож, кадастрыг бий болгох;
- § Ашиглах нөөц нь тогтоогдсон газруудад дунд чадлын (30-50 МВт) салхин паркууд байгуулан, эрчим хүчний төвлөрсөн системд холбон үр ашигтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- § Аймаг, сумдын нэвтрүүлэх чадвар нь хүрэлцэхгүй байгаа, хуучирсан дулааны шугам сүлжээг өргөтгөх;
- § Өндөр хүчин чадалтай нарны цахилгаан станц байгуулах олон улсын хамтарсан судалгааны хүрээнд говийн бүсэд туршилтын нарны цахилгаан станц байгуулах арга хэмжээ авах;
- § Нар, салхины эрчим хүчээр багийн төвүүдийг хангах;

§ Барилга байгууламжид өргөнөөр ашиглагдаж байгаа нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглах;

Гарах үр дүн: Аймгийн эрчим хүчний системийн үйл ажиллагаа жигдэрч, цахилгааны хэрэгцээгээр бүрэн хангагдах төдийгүй экспортолж эхэлнэ. Аймгийн 1000 хүн ам тутамд 1мвт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг бий болгоно. Энэ үзүүлэлтээрээ улсын хэмжээнд тэргүүлнэ.

1.4.3 Мэдээлэл, харилцаа холбооны хөгжил

Үндэслэл: Хүн амыг мэдээлэлээр хангах нь хөгжилийг бий болгох үндсэн нөхцөлийн нэг юм. Ховд аймаг нь 123-р станцаас 134-р станц хүртэл Мобикомын тоон релейгээр 2мвт-ын урсгалаар УБ хотын E10 –тай холбогдсон байна.

Ховд аймгаас Увс аймгийн чиглэлд 270 км агаарын шилэн кабель, АСШ-1159 км, ХХШ-256 км зэс болон өнгөт шугам ажиллаж, Булган сумын VSAT станцаар Булган, Алтай, Үенч сумдыг, Булган - Үенч сумдыг ОВ -12-3 нягтруулгаар, Жаргалант – Мөст хороонд ОВ-12-3, Ховд-Эрдэнэбүрэн ОВ 12-3 аар Дуут, Чандмань, Мөнххайрхан сум П309 нягтруулгын төхөөрөмжөөр 2 сувагтай ажиллаж, Булган суманд ZTE –ийн ZJX -10 маркын тоон 228 хэрэглэгчийн АТС, Мянгад суманд Hiphat 4000 маркийн 100 номерын тоон АТС тавигдан ажиллаж байна. Мөн хөдөөгийн малчин иргэдэд холбооны үйлчилгээг хүргэх зорилгоор 78 багт багийн холбоог суурилуулан ажиллуулж байна. Мобиком, Скайтелийн хөдөлгөөнт холбооны сүлжээнүүд үйл ажиллагаа явуулдаг. Хөдөөд цахилгаан шууданг орон нутгийн АТС –ийн суваг болон Монгол шуудан компаний Ховд дахь салбараар дамжуулан хүргэж байгаа боловч шуудан хүргэлтийн үйл ажиллагаанд техник тоног төхөөрөмжийн дутагдлаас үүдэн байна.

Холбооны үйлчилгээнд өндөр хурдны сүлжээ тоон системийг бүрэн нэвтрүүлэх, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах, мэдээллийн технологийг айл өрхөд хүргэх, холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейн шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулах шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Цахилгаан холбооны суурь, сүлжээг шинэчилж шилэн кабелийн сүлжээнд холбож аймаг, сумын хооронд дамжуулах системийн тоон технологит бүрэн шилжүүлж, багийн холбооны ашиглалтыг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- “Цахим Монгол” хөтөлбөр”, “Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө (2002)”, “Хөдөөгийн цахилгаан холбоог 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2003)”, “Шуудангийн салбарыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө (2003)”-г хэрэгжүүлэх;
- Аймгийн төвд холбоо, мэдээллийн төв байгуулах;
- Ховд-Улаангомьн чиглэлд өндөр хурдны шилэн кабелийн хот хоорондын сүлжээ байгуулах;
- Аймгийн зарим сумдыг мэдээлэл дамжуулах шилэн кабелийн сүлжээнд холбох;
- Аймаг, сумдын төвд мэдээлэл холбооны технологийн шинэ төрлийн үйлчилгээг, тухайлбал алсын зайн сургалт, теле-эмчилгээний өндөр хурдны үйлчилгээг тууштай нэвтрүүлэх;
- Аймгийн төвд телевизийн дахин дамжуулах станцыг шинэчилж, нэвтрүүлгийн чанарыг сайжруулах;
- Үүрэн телефон хэрэглэгчдийн хүрээг өргөтгөж бүх сум малчдыг хөдөлгөөнт холбоонд шилжүүлнэ.

- Айл өрхийг компьютержуулах арга хэжмээ авах
 - Интернетийн сүлжээг бүрдүүлж, компьютер, интернет хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх;
 - Улс орны хэмжээнд хэрэгжих нэгдсэн кодчлолын хүрээнд бүсийн мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх;
 - Нэгдсэн код (ZIP) бүхий шуудангийн хаягийн системийг боловсронгуй болгох;
 - Жаргалант, Дөргөн, Буянт сумдыг шилэн кабельд холбох;
 - CDMA -450-ZTE –холбоогоор Манхан, Дуут, Мянгад 35-50 км холбох;
 - Сумын төвийн холбох байгууламж тэжээлийн системийг дэс дараатайгаар бүрэн шинэчилэх;
 - Багийн холбооны тоног төхөөрөмжийг шинэчилж ашиглалтыг сайжруулах;
 - Аймгийн төвийн АТС-ийн багтаамжийг нэмэгдүүлэх замаар тоог 2500 –д хүргэх;
 - Мөнххайрхан, Эрдэнэбүрэн сумын аналогийн КАТС- 50/200-г солих;
 - Зарим сумдад DSMX суурлуулж ZTE-ийн АТС тавих;
 - Сумдын төвийг дэс дараатайгаар АТС-тай болгож нэгдсэн сүлжээнд холбох;
 - Дарви, Зэрэг, Манхан сумдыг 2006-2007 онд бусад сумдыг үе шаттайгаар хөдөлгөөнт холбооны системд холбох;
 - Аймаг, сумын төвийн хэрэглэгчдийг олон сувгийн нэвтрүүлэг үзэх боломжоор бүрэн хангах;
 - Бүх малчид, сумын төв суурин газрууд 4-с доошгүй сувгийн нэвтрүүлэг үзэх боломжтой болгох. Аймгийн байгууллага сумдыг интернетийн сүлжээнд холбох;
- Гарах үр дүн:** Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн сүлжээний үндэс суурь тавигдсан байна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Холбооны үйлчилгээнд тоон системийг бүрэн нэвтрүүлж, хиймэл дагуулын болон бага багтаамжийн радио релейний шугам, хөдөлгөөнт холбоог ашиглан баг, хот айл, малчдыг холбоожуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Орон нутгийн мэдээлэл, холбооны сүлжээний технологийн шинэчлэлтийг дуусгах;
- Аймгийн алслагдсан бүс нутгуудад утасгүй холбооны технологийг нэвтрүүлж бүрэн телефонжуулах;
- Сумын төвүүдийг шилэн кабелийн сүлжээнд өргөнөөр холбох;
- Үүрэн телефон хэрэглэх сонирхолтой хүн амын хэрэгцээг бүрэн хангах;
- Интернетийн сүлжээг сум, багийн түвшинд өргөтгөж, компьютер, интернет хэрэглэгчдийн хэрэгцээг бүрэн хангах;

Гарах үр дүн: Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн оновчтой сүлжээ бий болсон байна.

1.5. Аялал, жуучлалын салбарын хөгжил

Үндэслэл: Ховд аймаг нь аялал жуучлалын хөгжүүлэх байгаль, түүх дурсгал, олон ястны соёл, зан заншлын өвөрмөц арвин нөөцтэй аймаг юм. Эдгээр нөөц боломжийг оновчтой ашиглах замаар аялал жуулчлалын салбарыг эрчимтэй хөгжүүлж эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох шаардлагатай байна.

Ховд аймагт 2003 оны байдлаар 46 мянган аянчин, жуулчин хүлээн авах хүчин чадалтай аж ахуйн 14 нэгж байгууллага аялал жуучлалын үйл ажиллагаа явуулж байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Аялал жуулчлалыг аймгийн эдийн засгийн бие даасан салбарын хэмжээнд хүргэж оновчтой хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Ховд – Хар ус нуурын раойнд аялал жуулчлалын цогцолбор байгуулан уулын аялал, усан болон морин спорт аяллыг хөгжүүлэх;
- Дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын бааз, дэн буудлын сүлжээ байгуулах;
- Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн болон бусад зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргаж үзүүлэх зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулах, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах;
- Байгальд халгүй, орчин үеийн технологид суурилсан эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах арга хэмжээ авах;
- Олон ястны түүх сёлын онцлогийг харуулсан аялал жуулчлалын чиглэлээр гадаадын сонирхогч томоохон компаний хөрөнгө оруулалтыг татан оруулах арга хэмжээг зохион байгуулах;
- Дотоодын аялал жуулчлал хөгжүүлэх үүднээс юуны өмнө дотоодын амрагчид хүлээн авч байгаа Хар ус нуурын жуулчдын бааз болон бусад амралт сувиллын газруудыг тохижуулж, хүчин чадлыг нь бүрэн ашиглах нөхцөл бүрдүүлэх;
- Аялал жуулчлалын цогцолборыг аймгийн төвд барих;

Гарах үр дүн: Аялал жуулчлалын салбар түргэн хурдацтай хөгжих үндэс суурь тавигдаж, эдийн засагт тус салбарын эзлэх байр суурь нэмэгдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Аялал жуулчлалын салбарын материаллаг баазыг бэхжүүлэн, менежментийг боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Одоо ажиллаж байгаа жуулчдын бааз, амралт, сувилалын газруудыг тохижуулж, музейн үзмэрүүдийг баяжуулах арга хэмжээ авах;
- Аялал жуулчлалын маршрутын авто замыг сайжруулах зорилтыг дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх;
- Аймгийн төвүүдийн угсаатны зүйн музейнүүдийг засварлаж, музейн сан хөмрөгийг арвижуулах;
- Аялал жуулчлалын бүсүүдийг дотоодын болон олон улсын мэдээллийн сүлжээнд оруулж, зах зээлийн сурталчилгааг оновчтой хийх;
- Жуулчлалын мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлж, аялал жуулчлалыг нэгдсэн сүлжээнд холбож хөгжүүлэх, аялал жуулчлалын мэргэжилтэй боловсон хүчнийг ХоИС-ыг түшиглэн бэлтгэх;
- Аялал жуулчлалын маршрутын дагуух түүх соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах ажлыг идэвхжүүлэх;
- Зочид буудал, ангийн отог, зоогийн газар зэрэг үйлчилгээний газруудыг өргөтгөн тохижуулах, аялал жуулчлалын отог, баазуудын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг нь төрөлжсөн сургалтад хамруулах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх;
- Жуулчдын бааз, амралт сувиллын газрууд, аймаг орон нутгийн удирдлагатай нягт хамтран ажилладаг нөхцөл бүрдүүлэх;

Гарах үр дүн: Дотоод, гадаадын жуулчдын хэрэгцээ, сонирхолд нийцэхүйц материаллаг бааз бий болон, аялал жуулчлалын менежмент сайжирна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Ховд – Хар ус нуурын районд байгуулсан аялал жуулчлалын цогцолборыг Баруун бүсийн загвар бааз болгон хөгжүүлэх;
- ОХУ, Хятад, Япон, Солонгос зэрэг Ази, Европ, Номхон далайн орнуудад нэн түрүүнд сурталчлах замаар энэ бүс нутгийг олон улсын аялал жуулчлалын сүлжээнд хамруулах арга хэмжээ авах;
- Баруун бүсийн аймгуудын олон ястны соёл урлаг, ардын өв уламжлалыг харгалзан бүсийн тулгуур төв Ховд хотод Баруун бүсийн соёл урлагийн болон спортын төв цогцолборуудыг барих;
- Аялал жуулчлал хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийн дагуу орчин үеийн зочид буудал, жуулчны бааз, нүүдлийн отог шинээр барьж тохижуулан үйлчилгээний төрлийг олшруулах;
- Аялал жуулчлалд хөрөнгө оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжиж, жуулчдад хандсан сурталчилгааг өргөтгөх, Булган суманд Ярантын боомтыг түшиглэн аялал жуулчлалын бааз байгуулах;
- Дэд бүтцийг сайжруулж, зарим сумдыг байнгын цахилгааны эх үүсвэрт холбож, аялал жуулчлалын зам, гүүр барих, даваа гүвээний халтиргаа гулгааг засварлах;
- Дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлтэй зочид буудал, жуулчны бааз, дэн буудлын сүлжээ байгуулах, аялал жуулчлалын мэргэжилтэй боловсон хүчнийг ХоИС-ыг түшиглэн бэлтгэх;

Гарах үр дүн: Аймгийн аялал жуулчлалын үндсэн чиглэлүүдээр аялах амрагч, жуулчдын тоо олшрон, аймгийн эдийн засгийн өсөлтэд энэ салбарын эзлэх хувь хэмжээ нэмэгдэнэ.

1.6. Барилга, хот байгуулалтын хөгжил

Үндэслэл: Баруун бүсийн тулгуур төв Ховд хотын болон Алтай сумын шинэ ерөнхий төлөвлөгөө батлагдаад байна. Газрын харилцааны шинэтгэлийг эрчимжүүлэх, иргэн бүрт газар өмчлүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хуулийн хүрээнд 3672 иргэнд 669.7 га газар өмчлүүлээд байна.

Сүүлийн жилүүдэд барилгын үйлдвэрлэлт нэмэгдэж барилга, барилгын материал үйлдвэрлэлийн 8 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж Манхан, Дарви сумдад 250-300 хүний суудалтай соёлын төв, Үенч суманд 15 ортой хүн эмнэлэг, Жаргалант суманд Хас, ХААН, Зоос банкны барилга, 50, 75 хүүхдийн цэцэрлэг, 24 айлийн сууц үйлчилгээний төвүүд, хувийн хүн эмнэлэг, үйлдвэрийн газар, 960 хүүхдийн сургуулийн барилгыг шинээр барьж, тоосгоны шинэ 2 үйлдвэр ашиглалтанд ороод байна.

Аймгийн төвийн ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээт цэвэр усыг 9 гүний худагнаас хлораторын байгууламж, резервуар, түгээх шугамаар дамжуулан барилгажсан хэсгийн бүх обьектод 21 км шугамаар хүргэж, гэр хорооллын иргэдэд гүний 6 худаг, 14 усан сан ус түгээж хэрэглээний 90% хангаж байна. Албан байгууллага, аж ахуйн нэгж, хүн амнаас хоногт 3600 м3 усыг татан зайлуулж, картын системээр цэвэрлэгээ хийн, цэвэр ус, ариутгах татуургын системд бүрэн холбогдон үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээгээр 4-СӨХ үйл ажиллагаа явуулж, хог тээврийн үйлчилгээг хот тохижилт, иргэдэд үйлчлэх газраас хариуцан гүйцэтгэж байна.

Гэвч өнөөгийн байдлаар Ховд хот болон сумдын төв суурин газруудын хот байгуулалтын түвшин өсөн нэмэгдэж буй хэрэгцээнээс ихээхэн хоцорч байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Ховд хотыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу Баруун бүсийн тулгуур төв хот болгон хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүсийн тулгуур төв Ховд хотыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эрчимтэй хэрэгжүүлэх;
- Аймгийн төв, бичил бүсийн болон сумдын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг олон нийтийн оролцоотой шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах;
- Хил орчмын бүс нутагт хүн ам суурьшуулах зорилго бүхий урамшууллын бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвор суурьшлыг сайжруулах;
- Орон нутгийн нийтийн ахуй үйлчилгээний байгууллагын менежментийн болон үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх, шинээр бий болж байгаа тосгон сууринд хүн амын төвлөрлийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;
- Газрын албадыг шинэ техник, технологиор ханган, газрын харилцааны тухай мэдээлэл, бүртгэлийг иргэдэд нээлттэй байлган, үйлчилгээг шуурхай болгож, газрыг айл өрх бүрд үнэгүй өмчлүүлэх ажлыг хуулийн хугацаанд багтаан зохион байгуулах;
- Барилга хот байгуулалт, газар зохион байгуулалт, газар өмчлөх, эзэмших, ашиглах, үнэлэх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой мэдээллийн нэгдсэн санг бий болгох;
- Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдах барилга байгууламж, газрын харилцааны асуудлыг хэтийн хөгжилтэй уялдуулан шийдвэрлэх;
- Хот доторхи авто болон явган замыг ерөнхий төлөвлөгөөний дагуу тавих, тохижуулах;
- Гэр хорооллыг орон сууцны анхан шатны дэд бүтэц буюу цэвэр, бохир усны шугам сүлжээ, цахилгаан хангамжид холбож иргэдийг амины орон сууцтай болгох боломжийг бүрдүүлэх замаар орон сууцны хороолол бий болгон хөгжүүлэх, Ховд хотын Жаргалант муанд кадастрын зураглал хийх.

Гарах үр дүн: Аймаг, сумын төвүүдэд хүн амын тогтвор суурьшиж хот хөгжлийн цэгцтэй бодлого хэрэгжинэ.

Тэргүүлэх зорилт 2. Хүн амын өсөлт, хэрэгцээтэй уялдуулан аймгийн орон сууцны хангамжийн түвшинг нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

Монгол улсын Засгийн газрын “40 000 айлын орон сууц барих” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвд 100 айлын орон сууцны шинэ хороолол барих;

- “Орон сууц” сан бүрдүүлж, эн тэрүүнд төрийн албан хаагчид, залуу гэр бүлийг орон сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Орон сууцны барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжийг урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэн дэмжих;
- Гэр хорооллын иргэд орон сууцны нөхцлөө сайжруулах, орон сууцандаа хөрөнгө оруулалт хийх сонирхлыг нь нэмэгдүүлэх;
- Орон гэргүй ядуучуудыг орон байраар хангах боломжийг судлан хэрэгжүүлж эхлэх;
- Сум бүрт 4 айлын орон сууц барих;
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих;
- Хөдөөний хүн амын орон сууцны нөхцлийг сайжруулах хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж эхлэх;

Гарах үр дүн: Аймаг, сумын төвүүдийн хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан орон сууцны хангамжийн түвшинг 40-50 хувьд хүрнэ.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, Баруун бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон төв болгох;

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Зах зээлийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан хот суурингуудын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжид техник технологийн шинэчлэлт хийж, цэвэрлэгээний түвшинг сайжруулах, бага оврын цэвэрлэх байгууламжийг хэрэглэх арга хэмжээ авах;
- Аймгийн төв талбай залуучуудын цэцэрлэгийн тохижилтыг сайжруулах.
- Хотын гэрэлтүүлэг гоёл чимэглэлийг өөрчлөн сайжруулах .
- Нэрэмжит гудамж цэцэрлэг бий болгон тохижуулах.
- Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, төв гудамжинд гоёлын ургамлаар бүрэн цэцэгжүүлж тарималжуулах.
- Ховд хотын дурсгалт газруудыг сэргээх.
- Хүн амын суурьшлын шинэ хорооллууд байгуулах арга хэмжээ авах;
- Аймгийн үйлдвэрлэл, хэрэглээ, хүн амын өсөлттэй уялдуулан инженерийн дэд бүтцийн шугам сүлжээг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор тодорхой төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Бичил бүсийн төв, сумд, багийн төвүүдийг шинэчлэн тохижуулах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлэх;
- Загвар суурин байгуулж, тохижуулах арга хэмжээ авах;

Гарах үр дүн: Аймгийн хүн ам тав тухтай ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангасан, экологид ээлтэй, эдийн засгийн хувьд биеэ даасан, гадаад, дотоод харилцаа сайтай орчин үеийн хот байгуулалт хөгжинө.

Тэргүүлэх зорилт 2. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг эрс дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төв, сумдын бага орлогтой болон залуу гэр бүлийг орон сууцаар хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл боловсруулан хэрэгжүүлэх;
- Орон сууцны барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжийг татвараас бүрэн чөлөөлөх урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэх;
- Орон гэргүй байгаа ядуучуудыг орон байраар хангах цогц арга хэмжээ авах;
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр идэвхтэй дэмжих;

Гарах үр дүн: Аймгийн төвийн хүн амын орон сууцны хангамжийн түвшинг 50-60 хувьд хүргэснээр хүн амын тав тухтай амьдрах ахуйн нөхцөл сайжирна.

ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ

2.1. Хүн амын өсөлт, хүний хөгжлийг хангах талаар

Үндэслэл: Ховд аймагт 2005 оны байдлаар 91,7 мянган хүн оршин сууж байгаа нь улсын нийт хүн амын 3.6 хувьтай тэнцэж байна. 2005 оны байдлаар 1000 хүнд ногдох төрөлт 19.3, нас баралт 4.7, цэвэр өсөлт 14.6 байгаа нь 2000 оныхоос төрөлт 29.4хувь, цэвэр өсөлт мөн 33.5 хувиар буурчээ. Шилжих хөдөлгөөн их байгаа

нь хүн амын жилийн дундаж өсөлт буурах нөхцлийг бий болгож байна. Сүүлийн 5 жилд нийт 10,1 мянган хүн шилжин явжээ.

Ховд аймагт хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлт харьцангуй доогуур түвшинд байна. 2002 онд хүний хөгжлийн индексийн улсын дундаж 0.697 байхад Ховд аймаг 0.652, 2003 онд улсын дундаж 0.690 болж өссөн байхад Ховд аймагт 0.646 болж буурчээ.

Иймд хүн амын гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулж, хүн амын өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүний хөгжлийн индексийг дээшлүүлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг 1.2 хувьд хүргэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн бодлого төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлдэг механизм бий болгох;
- Залуу гэр бүл, шинээр төрсөн хүүхдийг дэмжих сан байгуулж ажиллуулах;
- Ховд хот болон сумдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх замаар хүн ам төрж, өссөн нутагтаа тогтвор сууршилтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх;
- Хот, хөдөөгийн иргэдийн амьжиргааны түвшингийн ялгааг багасгаж, улмаар адил тэгш болгох боломжоор хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх;
- Амьдралын таатай нөхцлийг бүрдүүлснээр 2010 он гэхэд хүн амын дундаж наслалтыг 65-д хүргэх;
- Бичиг үсэг үл мэдэх явдал, сургууль завсардалтыг арилгах, улмаар боловсрол, эрүүл мэнд, технологийн салбарт хөрөнгө оруулалт хийх, мэдээллийн хүртээмжийг сайжруулах бодлогыг тууштай хэрэгжүүлэх;

Гарах үр дүн: Аймгийн хүн амын жилийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Хүнийг бүх талаар хөгжүүлэн, аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 0.690-ээс бууруулахгүй байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, сумдын түвшинд бүх шатны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэн, сургалтын чанарыг сайжруулах;
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тууштай сайжруулах;
- Аймгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтцийг шинэчлэх бодлоготой уялдуулан хүн амын орлогыг тасралтгүй нэмэгдүүлэх;
- Иргэн бүрт өөрийгөө боловсруулж хөгжүүлэх, амьдрах ухааныг эзэмшүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн үзүүлэлтүүд чанаржиж дээшилнэ.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг 1.5 хувьд хүргэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг, сумдын түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлэх арга механизмыг улам боловсронгуй болгох;
- Аймгийн эдийн засгийн өсөлтийг түргэсгэн ажлын байрны хангамжийг сайжруулах замаар гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг эрс бууруулах;

- Төрөлтийг дэмжих зорилгоор өрхийн орлогод ногдох албан татварт хөнгөлөлт үзүүлэх, өрхийн хүүхдийн тоо, насны ялгааг харгалзан тэтгэлэг олгох зэрэг арга хэмжээнд хамрах хүрээг өргөтгөх;
- Нийгэм, эдийн засаг, орчин ахуйн ая таатай нөхцлийг бүрдүүлэх замаар 2015 он гэхэд аймгийн хүн амын наслалтыг дунджаар 66-д хүргэх;
- Аймаг, сумдын түвшинд хүн амын бичиг үсэг үл мэдэх явдлыг арилган, насан туршдаа боловсролоо дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

Гарах үр дүн: Хүн амын жилийн дундаж өсөлт тогтворжиж, улмаар нэмэгдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Хүнийг хөгжүүлэх боломжийг бүрэн ашиглах замаар аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийг **0.695-аас** доошгүй түвшинд хүргэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, сумдын түвшинд хүн амын орлогыг нэмэгдүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээнүүдийг тууштай үргэлжлүүлэх;
- Албан ба албан бус боловсролын тогтоцоог боловсронгуй болгож, бүх шатны боловсролын хүртээмжийг сайжруулах;
- Нийт малчдыг зайны сургалтад хамруулах оновчтой арга, хэлбэрийг сонгон нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэлийн салбарын бүтэц, өсөлттэй уялдуулж мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог оновчтой болгох;

Гарах үр дүн: Хүний хөгжлийн индексийг улсын дундаж түвшинд хүргэнэ.

2.2. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар

Үндэслэл: Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин 4.1, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх нийт өрхийн 44.4 хувийг эзэлж байгаа нь улсын дунджаас өндөр байна. Ядуу өрхийн дийлэнх нь аймаг, сумын төвд амьдарч байна. Иргэд бизнес эрхэлж бие даан амьдрах мэдлэг, дадлага, туршлага, дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс салж чадахгүй байна. Хөдөлмөрийн насны хүн амын 34,5 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, ажилгүйдлийн түвшин улсын дунджаас өндөр байгаа бөгөөд ажилгүйдэл дагасан ядуурал өсч байна.

Иргэдэд хувиараа хоршин хөдөлмөр эрхлэх, орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгоход хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж чадахуйц мэргэжлийн боловсрол олгох, зээлийн хөрөнгийн ашиглалтийг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн орон нутагт бодит ажилгүйдлийн түвшинг мэдэгдэхүйц хэмжээнд бууруулах шаардлагатай байна.

Ажилгүйдлийг бууруулж, ядуурлын үндсыг арилгах, ядруулаас гарах оновчтой арга зам, механизмыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Хүн амыг тогтвортой ажлын байраар ханган орлогыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг тогтвортой бууруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төв, бичил бүсийн төвийн түвшинд “Нийгмийн үйлчилгээний төв”, нийгмийн хамгаалал, даатгал, хөдөлмөр эрхлэлтийн иж бүрэн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх “Нийгмийн хамгааллын төв”, орон нутгийн хөгжлийн төвүүдэд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг ажиллуулах;
- Ховд хотод хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээлэл сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн сүлжээгээр үйлчилдэг болох;

- Сумын нийгмийн үйлчилгээний төв, аймгийн нийгмийн халамжийн албадын ажилтнуудыг давтан сургах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
- Сум дундын нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулан, өргөжүүлэх;
- Нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд аймгийн хүн амыг бүрэн хамруулах;
- Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд албан бус салбарт ажиллагсдын хамралтын хэмжээг нэмэгдүүлэх;
- Ядуу, бага орлоготой өрхийг уламжлалт мал маллагааны арга барилд сургах, малжуулах, тэднийг мал сүргээ тогтвортой өсгөж, бие даан ажиллаж амьдрах нөхцөл бололцоог өөрсдөө бий болгоход сургаж хэвшүүлэх замаар малчин өрхийн амьжиргааг дэмжих;
- Ядуу иргэдийн санал санаачлагыг улсын болон хувийн аж ахуйн байгууллагууд дэмжиж энэ талын сургалт сурталчилгааг өргөтгөх;
- Олон малтай хүн хүчний дутагдалтай өрхөд гэрээт малчны хэлбэрээр ядуу өрхөөр туслалцуулан ажиллуулж, фермерийн аж ахуй болгохыг дэмжих;
- Хоршоо байгуулах замаар ядуу өрхөөр тодорхой хэмжээний мал маллуулах ногоо тарих, байгалийн дагалдах баялгийг ашиглах, гахай шувуу зэрэг туслах аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Төмс хүнсний ногоо, жимс жисгэнэ тарих, гахай тахиа үржүүлэх зэргээр туслах аж ахуй эрхлэхэд айл өрхүүдийг хамруулах ажлыг сум бүрт хэрэгжүүлэх;
- Сум багийн төвд халуун ус үсчин, оёдолчин, гутал засвар зэрэг ахуйн үйлчилгээний цэг салбар нээн ажиллуулах, явуулын үйлчилгээ бий болгоход туслах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах ялангуяа цөлжилтөөс хамгаалах, ойн зурвас байгуулах замаар газрын хөрс, бэлчээрийг хамгаалах ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг оролцуулах ажлыг өргөнөөр зохион байгуулах;
- Ядуурлыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллгааг орон нутагт идэвхжүүлж, уялдаа холбоог сайжруулах;
- Нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй залуучууд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг өргөн хамруулах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх;
- Жижиг дунд үйлдвэр, хүн амын ахуйн үйлчилгээг дэмжих, дэд бүтэц, аялал жуучлалыг хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг түлхүү чиглүүлэх;
- Нийтийг хамарсан ажлыг байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээх зам барих, цөлжилттэй тэмцэх зэрэг хөдөлмөрийн багтаамж ихтэй үйлдвэрлэл үйлчилгээний салбарт түлхүү зохион байгуулах;
- “Мянганы зам”, “Ногоон хэрэм” төслүүдийн хүрээнд ажлын түр болон байнгын байраар хангах ажлыг зохион байгуулах;
- МСҮТ байгуулан хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжил олгох болон мэргэжлийн ур чадварын сургалтанд ажилгүй залуучууд нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулж сургалтын чанар үр дүнг сайжруулах;
- Хоршоо, бүлэг, нөхөрлөл байгуулах, ажлын байр нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын санаачлагыг дэмжин хамтран ажиллах;
- Ажлын байр шинээр бий болгосон буюу ажилгүй иргэдэд шинээр мэргэжил олгох, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулсан ажил олгогчид дэмжлэг үзүүлэх;
- Ажилгүй иргэдэд мэргэжил, дадлага олгох сургалтуудыг зохион байгуулж, шинээр ажилд орсон залуучуудад гарааны зээл тусламж олгох иргэд байгууллагуудын идэвх санаачлагыг дэмжих;

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан ажилгүй иргэн, ажил хайгчдын сул чөлөөтэй ажлын байранд зуучлах, зөвөлгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээллээр хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах.
Гарах үр дүн: Жилд дунджаар 1500 ажлын байр шинээр бий болж, ажилгүйдлийн түвшин 2.0 хувь болж буурсан байна.

Тэргүүлэх зорилт 2. Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн халамж, үйлчилгээг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- “Тогтвортой амьжиргааг дэмжих” төслийн хүрээнд ядуу эмзэг хэсэгт туслах зорилгоор банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах;
- Бүтэн өнчин, тэнэмэл, нэн ядуу өрхийн хүүхдүүдийг байрлуулж хооллон, сургалт явуулах халамжийн төвүүдийн үйлчилгээг нэмэгдүүлэн, амьдралын арга ухааныг зааж сургах ажлыг өргөжүүлэх;
- Ядуу иргэд, орон гэргүй хүмүүсийг гэр хашаа, орон сууц худалдан авах, барих, орон байраа өргөтгөх, засварлах боломж олгох зорилгоор орон сууцны зээлийн үйлчилгээг сайжруулах;
- Хоол тэжээлийн дутагдалд орж буй шалтгаан, нийгмийн үр дагаврыг судлан ядуу иргэдийн хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Ахмад настанд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтийг боловсронгуй болгох;
- Тахир дутуу иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээ, хүртээмжийг тэдний амьдралын чанар онцлогийг харгалзан нэмэгдүүлэх;
- Нийгмийн эмзэг, ядуу, нэн ядуу иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болоход нь зөвөлгөө өгөх;
- Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн халамж, тусламж үйлчилгээний үр өгөөжийг үнэлэх, хяналт тавихад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;
- Ахмад настны “Цагаан уул” амралт сувилалын газар чийрэгжүүлэлтийн танхим нээн ажиллуулах;
- Дуутын рашаан сувилалын амралтыг нээн ажиллуулах;
- Хүүхдийн хөгжлийн төв барьж ажиллуулах;
- Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг зөвөлгөө өгөх төв байгуулах;

Гарах үр дүн: Эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх нийгмийн хамгааллын тогтолцоо боловсронгуй болж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж сайжирна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1: Амьжиргааны баталгаажих төвшингөөс доогуур орлоготой иргэдийг амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгож, нийгмийн хамгааллын хүртээмж, үйлчилгээг шинэ шатанд гаргах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо, фермерийн аж ахуй байгуулах, аялал жуулчлал хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийг бүх талаар дэмжих;
- Бичил аж ахуйн нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес-инкубаторын төвийг байгуулах;
- Залуучуудад ажлын байр шинээр бий болгож байгаа аж ахуйн нэгж, иргэдэд татварын бодлогоор хөнгөлөлт үзүүлэх;
- “өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих” дэд хөтөлбөрийг хоршоо, фермерийг дэмжих бодлоготой нягт уялдуулан хэрэгжүүлэх;

Гарах үр дүн: Ажилгүйдлийн түвшин, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хувь хэмжээ буурсан байна.

Тэргүүлэх зорилт 2. Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төвийн асрамж, халамжийн төвүүдийн үйл ажиллагааг чанаржуулж, бүтэн өнчин, тэнэмэл болон нэн ядуу өрхийн хүүхдийг байрлуулж хооллон, сургалт явуулах халамж үйлчилгээний төвүүдийг шаардлагатай газарт шинээр байгуулж, амьдралын арга ухааныг зааж сургах;
- Хөдөлмөр эрхлээгүй хүмүүс, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг дэд бүтэц, хот, нийтийн аж ахуйн болон нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, үйлчилгээний ажлын хэсгийг гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоонд шилжих;
- “Нийгмийн халамжийн сан”-гийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- Тахир дутуу иргэдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний хүрээ, хүртээмжийг тэдний амьдралын чанар, онцлогийг харгалзан нэмэгдүүлэх;
- Ахмад настанд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтийг сайжруулж, өрхийн тэтгэмжийн төрлийг шинээр бий болгох;

Гарах үр дүн: Ажлын байр нэмэгдэн, нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна.

2.3. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар

Үндэслэл: Ховд аймагт Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангамж, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй санхүүгийн чадавхи хязгаарлагдмал материаллаг баазын хангамж хүрэлцээ дутмаг сум, сум дунд, өрхийн эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Ховд аймагт БОЭТ 1, сум дундын эмнэлэг 2, сумын эмнэлэг 14, өрхийн эмнэлэг 6, хувийн хэвшлийн ортой 4 эмнэлэг ажиллаж байна. БОЭТ нь байгуулагдаад 4 дахь жилдээ ажиллаж байгаа боловч оношлогооны зарим тонгог төхөөрөмж дутагдалтай /тархины цахилгаан бичлэгийн аппарат, рентгений 1 харалтын аппарат болон хүнд өвчтөний хяналтын монитори аппарат г/м/ байдгаас Улаанбаатар хот руу явах өвчтөний тоо төдийлөн буурахгүй байна.

Сум дундын болон сум, өрхийн эмнэлгүүдэд зайлшгүй шаардлагатай зарим багаж тоног төхөөрөмж, оношлуурууд дутагдаж байна.

Эх хүүхдийн эндэгдэл буурч байгаа боловч энэ бууралт нь тогтвортой байх магадлал бага нэн ялангуяа эмзэг бүлгийнхэнд хүрэх эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

2005 оны жилийн эцсийн тайлангаар 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19,3 промилль, эхийн эндэгдэл 100000 амьд төрөлтөнд 56.1 байна.

Хүрээлэн буй орчин ажил амьдралын ахуй нөхцлөөс шалтгаалсан өвчлөл их байна. Халдварт өвчин тууштай буурахгүй нэн ялангуяа БЗХӨ өвчин нэмэгдэж байна.

Иймд Ховд аймгийн Эрүүл мэндийн тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай найдвартай хүргэх эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэх шаардлага тулгамдсан асуудлын нэг болж байна.

Нэгдүгээр үе шат (2007-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэн хүн ам эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах ая таатай нөхцлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ховд хотын онцлог, хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан хотын нутаг дэвсгэрийн 10%-аас доошгүй хэсэгт ногоон байгууламж байгуулах;

- Байгаль орчныг бохирдлоос сэргийлж хог хаягдлыг зайлуулах устгах талаар аймгийн онцлогт тохирсон цогц бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Ховд аймгийн хүн амын өвчлөлийн байдлыг тогтоох судалгаа явуулж эрүүл мэндийн байдлыг хянан тандаж мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх;
- Эрүүл аймаг, хот, сум, баг болох санаачилгыг хөхүүлэн дэмжиж,иргэний нийгмийн нөөцийг дайчлан хувь хүн,хамт олны оролцоог нэмэгдүүлэх;
- Гэр хорооллыг цэвэр,бохир усны төвлөрсөн системд холбох ажлыг эхлүүлж айл өрхийг халуун ус,саунтай болгох үүсгэл санаачилгыг хөхүүлэн дэмжих;
- Ховд аймгийн хүн амын ундны усны чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн сацуу рашааны эх үүсвэрийг бүрэн хамгаалалт,хяналтад авах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Олон улсын хол хориот өвчнөөс аймгийн хүн амыг хамгаалахад чиглэсэн лаборатори, оношлогоо эмчилгээний явуулын багийн чадамжийг сайжруулах;
- Халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг сайжруулах, тусламж, үйлчилгээ хүртэхэд хүндрэлтэй өрхийн хүүхдийн дархлаажуулалтанд хамрагдалтыг 95 хувь хүргэж дархлаажуулалтанд хавсарсан вакцин нэвтрүүлэх замаар хатгалтын тоог цөөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- ЭМШУИС болон ЭШ-ний хүрээлэнтэй хамтран нутагшмал эмгэг, эрсдэлтийн хүчин зүйлийг илрүүлэх, сэргийлэх, анагаах арга хэмжээг цогцоор нь авах;
- “Эх хүүхдэд ээлтэй аймаг” болох чиглэл баримтлан эх, нялхасын эрүүл мэндийг сайжруулах, эндэгдлийг бууруулах ялгамж заагтай бодлого хэрэгжүүлэх замаар эхийн болон нялхасын эндэгдэл, 5 хүртэлх хүүхдийн нас баралтыг бууруулан мянганы зорилтын түвшинд хүргэх;
- Нэн ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, тахир дутуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчин нөхцөл бүрдэх үндэс суурь тавигдана.

Тэргүүлэх зорилт 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Өмчийн олон хэвшилд тулгуурласан аймгийн эрүүл мэндийн оновчтой, нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх;
- Аймгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж эмнэлгийн дагнасан болон хоршсон тусламж яаралтай тусламж, уламжлалт эмчилгээ нөхөн сэргээх болон сувилах эмчилгээг хөгжүүлэх бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх;
- Ховд аймаг дахь БОЭТ-ийн үйл ажиллагааг чанаржуулахад чиглэсэн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- БОЭТ, сургалт эрдэм шинжилгээний бааз, ажиллагсад суралцагчдын амьдрах орон байр, дэд бүтэцтэй оношлогоо, эмчилгээний цогцолбор төв байгуулах;
- Ховд аймгийн хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох шалтгааныг илрүүлэх, анагаах технологийн байдалд үнэлгээ өгөх замаар хамгийн зохимжтой технологийг сорчлон нэвтрүүлэх;
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ хүртэхэд бэрхшээлтэй өрх, хүн амд тусламж, үйлчилгээг хүргэх явуулын үйлчилгээ бий болгох;
- Бүх сумдыг ЭХО аппарат цахилгаан, техник оншилгооны тоног төхөөрөмжөөр хангах;
- Эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт,засвар үйлчилгээний төв байгуулах асуудлыг шийдвэрлэх;
- Алсын зайн оношлогоо,сургалт зөвлөгөө өгөх мэдээллийн бүсийн сүлжээ байгуулах, эрүүл мэндийн мэргэжилтний тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн оновчтой бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;

- Нөөцийн /буюу бүтэц/ үйл явцын /буюу технонологи/, үр дүнгийн /буюу төгсгөл/ стандартын түвшинд иж бүрэн үнэлгээ хийх замаар эмнэлгийн тусламжийн чанарыг дээшлүүлэх арга замыг тогтоон хэрэгжүүлэх;

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд үйлчлүүлэгчид ээлтэй, үр дүнтэй, үр ашигтай, өрсөлдөөн бүхий тогтолцоо бүрдүүлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар дээшлэнэ.

Тэргүүлэх зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Эрүүл мэндийн салбарт зарцуулах санхүүжилтийн эх үүсвэрийг зохицуулан төсвийн төлөвлөлтийг сайжруулах;
- Эм эмнэлгийн хэрэгслийн хангамжийн сүлжээ байгуулах, эмнэлгийн суурь технологи хөгжүүлэх боломжийг судлаж шийдвэрлэх;
- Хүн эмнэлгийн болон эхчүүдийн амрах байруудыг засварлан тохижуулах, шинээр барих;
- Ховд аймгийн ЭМГ-т эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэн шаардлагатай эм тарианы нөөцтэй болгох арга хэмжээ авах;
- Өрхийн болон сумын эмнэлгүүдийг санхүүжүүлдэг механизмыг боловсронгуй болгож, эмнэлгүүдийг магадлан итгэмжлэлд бүрэн хамруулах;
- Эмнэлгийн боловсон хүчин, эмч, сувилагч нарын мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч, орчин үеийн тоног төхөөрөмжийг эзэмшүүлэх, анагаах ухааны орчин үеийн ололттой танилцуулах сургалт, зөвлөгөөнийг тогтмолжуулах;
- Ажлын байранд нь эмнэлгийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх;
- Сумдын захиалгаар мэргэжлийн эмч бэлтгэх замаар эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- Одоо байгаа эмч нарын хүрэлцээ, эрүүл мэндийн анхан шатны бүртгэл, мэдээллийн компьютержсэн сүлжээний эхлэлийг тавих;
- Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хамралтыг нэмэгдүүлэх;
- Сумын түргэн тусламжийн автомашины паркийг жил бүр 15-аас доошгүй хувиар шинэчлэх;
- БОЭТ-н тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний хангамжийн түвшинг дээшлүүлж, өвчтөнийг дагаж ирсэн хүмүүсийг байрлуулах байр барьж бүсийн бусад аймгуудаас өвчтөн хүлээн авах нөхцөлийг сайжруулах;

Гарах үр дүн: Оношлогоо, эмчилгээ, сувилгааны чанарын түвшинг дээшлүүлэх боломж нэмэгдэн, иргэдэд хүрэх хүртээмж сайжирна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Эрүүл мэндийн бүх шатны тусламж, үйлчилгээний орчин үеийн тогтолцоог төлөвшүүлэн оношлогоо, эмчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулан эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- Бүсийн оношлогоо эмчилгээний төвд эмнэлгийн тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилж, теле оношлогоо, эмчилгээнд хамрах хүрээг эрс нэмэгдүүлэх;
- Аймгийн хүн амын ундны усны эх үүсвэрийн 90-ээс доошгүй хувьд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож рашааны эх үүсвэрийг бүрэн хамгаалалт, хяналтад авах;

- Мэдээллийн технологийн ололт дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлээр тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх;
- Хувийн болон олон нийтийн өмчид суурилсан эмнэлгийн байгууллагуудыг дэмжин хөгжүүлж оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

Гарах үр дүн: Эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчин бүрдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Санхүүгийн нөөцийг оновчтой зөв зохистой ашиглах, ялангуяа хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрэн дайчлах, оновчтой ашиглах, дэмжлэг авах хөшүүрэг бий болгох;
- Аймгийн төв, сумдын төвд бялдаржуулах төв байгуулан ажиллуулах;
- Аймгийн Нийгэм халамж үйлчилгээний төвийг түшиглүүлж ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, асран сувилах газруудыг байгуулах /Нэвт, Цагаан уул/
- Тахир дутуу иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөтгөж материаллаг баазыг нь улам бэхжүүлэх;
- БОЭТ болон сумуудын эмнэлгийн байрыг засварлах, шинээр барих ажлыг эрчимжүүлэх;
- БОЭТ-д соронзон томограф ашиглах эрэлт хэрэгцээг судлан шийдвэрлэх;

Гарах үр дүн: Өмчийн олон хэвшилд суурилсан эмнэлгийн байгууллагуудын тогтолцоо бүрдэж, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын түвшин дээшилнэ.

2.4. Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшүүлэх талаар

Үндэслэл: Төр засгаас хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлсэний үр дүнд 2006 оны байдлаар аймгийн 14-69 насны хүн амын 73.0 хувь нь суурь ба түүнээс дээш шатны боловсролтой болж сургуулийн насны хүүхдийн /7-15нас/ 94 хувь, сургуулийн өмнөх насны хүүхдийн /2-6/ 49хувийг хамран сургаж бичиг үсэг үл мэдэгчдийн тоо 2000 оныхоос 30.8 хувиар сургууль завсардагчдын тоо 2.4 дахин буурсан байна.

Сургалтын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт болох сурлагын амжилт сүүлийн 5 жилийн дунджаар 1.4 хувиар суралцагсадын тоо өмнөх жилүүдийнхээс 1.8 хувиар ахисан байна.

Гэвч боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай байна.

Мөн соёл урлагийн байгууллагуудын урын санг баяжуулах музей, театр, ХДТ, номын санг төрөлжсөн эрдэм судлалын ажлын орон тооны бус судлаачдын баг бүрдүүлэх, иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанарыг шаардлагын хэмжээнд хүргэх, соёлын өв тээгчдийг сурталчилах өвлөн авах ЕБС-ийг түшиглэн ардын уламжлалт урлагийн сургалтуудыг нээж хичээллүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалах хамгаалах ажлыг цогцоор шийдвэрлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулиудын сургалтын чанарыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ерөнхий боловсролын сургуулиудын байршил, хэв шинжийг орон нутгийн засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулан оновчтой тогтоох;
- Сум бүрт сургуулийн өмнөх боловсролыг гэрийн нөхцөлд ойртуулах арга хэмжээ авч, хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалтыг эрс нэмэгдүүлэх;

- Сургууль завсардах явдлыг эрс багасган, суурь боловсролын хамран сургалт /бохир жин/–ыг нэмэгдүүлэх;
- ЕБС-ийг 11 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлж, 12 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэлийг ханган, шилжиж эхлэх;
- ЕБС-ийн дунд, ахлах ангид суралцагчдын хүйсийн тэгш бус байдлыг арилгах;
- МСҮТ, ЕБС, цэцэрлэгийн зарим ажил үйлчилгээг гэрээ, түрээсийн хэлбэрт шилжүүлэх;
- Англи хэлийг хоёр дахь албан хэл болгоход чиглүүлэн сургалтыг чанаржуулах, мөн орос, хятад хэлний гүнзгийрүүлсэн сургалт явуулах;
- Сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чадвар, дадалтай болгох ажлыг зохион байгуулах;
- Төрийн бус өмчийн сургуулийг аймаг, сумдын төвд байгуулан ажиллуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх оновчтой арга хэлбэрийг сонгох, тухайлбал явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэг ажиллуулах;
- Боловсрол, соёлын байгууллагын удирдлагын чадавхийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Хөдөөгийн сургуулиудыг мэргэжлийн багшаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагуудыг төрөлжүүлэн нэгтгэхийн сацуу дэргэд нь багшлах боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх сургалт-мэдээллийн төвүүдийг байгуулах;
- Оюуны багтаамж ихтэй, өндөр технологи эзэмшүүлэх зорилгоор залуучуудыг өндөр хөгжилтэй орнуудад сургах арга хэмжээ авах;
- Гадаад орнуудын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа өргөтгөх; гадаадад суралцагсдын тоог нэмэгдүүлэх
- Ховд Их Сургуулийг түшиглэн Баруун бүсийн багш нарын мэргэжил дээшлүүлэх болон эрдэм шинжилгээний салбар байгууллагыг нээн ажиллуулах, мэргэжлийн чиглэлийг өөрчлөн орон нутагт хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх
- Аймгийн төвд МСҮТ-ийг шинээр байгуулах
- Их, дээд сургуультай хоршсон шинжилгээ судалгааны төрөлжсөн байгууллага, салбар, мэдээллийн технологийн төвүүд байгуулж ажиллуулахыг урамшуулан дэмжих; жилд
- Өндөр мэргэжилтэй багш нар, соёлын төвийн ажилтнуудыг орон нутагт ажиллуулах эдийн засгийн урамшууллын шинэ хөшүүрэг бий болгох;
- Аймгийн төвд Баруун бүсийн хүүхдийн хөгжлийн төв байгуулах

Гарах үр дүн: Боловсролын тогтолцоо болон сургалтын байгууллагын хэв шинж, үйл ажиллагаа олон улсын жишигт ойртоно.

Тэргүүлэх зорит 2. Албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Албан бус боловсрол олгох **Баруун** бүсийн нэгдсэн сүлжээ бий болгох хөтөлбөрийг бүсийн бусад аймгуудтай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх;
- Албан бус болон зайны сургалтыг хүн амд бичиг үсэг сургах, боловсролын түвшингээ дээшлүүлэх, бизнес, зах зээлийн мэдлэг, зохистой хэрэглээний чадвар олгоход чиглүүлэх;
- Албан бус боловсролын тогтолцоонд ажиллах орон тооны болон орон тооны бус багш бэлтгэх ажлыг ээлж дараагаар хэрэгжүүлэх;
- Хүн амын бие дааж боловсролоо дээшлүүлэх санаачлагыг дэмжин аймгийн боловсрол соёлын газрын дэргэд бие дааж суралцагчидад зөвлөгөө өгөх төвийг байгуулан үйл ажиллагааг эрхэлж хэрэгжүүлэх;

Гарах үр дүн: Албан бус боловсрол ба зайны сургалтын үйлчилгээний тогтолцооны үндэс суурь тавигдаж, менежмент нь сайжирна.

Тэргүүлэх зорилт 3. Боловсролын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Сумын соёлын төв аймгийн ХДТ-г урлаг соёлын хосолсон үйлчилгээтэй байгууллага болгон ажиллуулах замаар соёлын үйлчилгээний оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Аймгийн төвийн болон сумдын цэцэрлэгүүдийн тоглоом наадгай, ерөнхий боловсролын сургуулиудыг орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг сайжруулж, номын сангийн үйлчилгээ фондыг нэмэгдүүлэх;
- Хүүхдийн цэцэрлэг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр, дотуур байрыг засварлах, цахилгаан дулаан хангамжийг сайжруулах, зарим сургуулийн хичээлийн байранд өргөтгөл хийх ажлыг дэс дараагаар зохион байгуулж хэрэгжүүлэх;
- Аймгийн төвд байгуулагдсан МСҮТ-ийн материаллаг баз орчныг сайжруулах тоног төхөөрөмжөөр ханган, мэргэжилтэй ажилчин бэлтгэх ажлыг чанартай зохин байгуулах;
- Боловсрол соёлын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүхий л талаас дэмжих, урамшуулах, гадаад орныг мэргэжлийн байгууллагуудаас боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байх талаар дэмжих;
- Цэцэрлэгүүдийг компьютержүүлэх ажлыг шийдвэрлэх;
- Хөдөөгийн ЕБС-ийг компьютерийн сүлжээнд холбох арга хэмжээг улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх;
- Гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийг бүх талаар дэмжих;

Гарах үр дүн: Бүх шатны боловсролын сургуулиудын материаллаг бааз бэхжин, сургалтын чанарыг сайжруулахад үзүүлэх нөлөөлөл нь нэмэгдэнэ.

Тэргүүлэх зорилт 4. Урлаг, соёлын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Суманд соёлын төв, бичил бүсийн төвд урлаг-соёл-спортын төв, аймгийн төвд мэргэжлийн урлаг-соёлын хосолсон үйлчилгээтэй байгууллагууд ажиллуулах замаар соёлын үйлчилгээний оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Угсаатны зүй, үндэстэн ястны соёлыг хадгалж хамгаалах төвийг аймгийн төвд байгуулах;
- Сумдын номын сан, музей, театр, соёлын төвүүдийн байрны хангамж, материаллаг баазыг бэхжүүлэн үйлчилгээг өргөжүүлж, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулах арга хэмжээ авах;
- Аймгийн номын санг “Номын өргөө” болгон зохион байгуулж, түүний зохион байгуулалт, үйлчилгээний төрөл хэлбэр, санхүүжилтийн механизмыг тогтоох;
- Олон ястны өвөрмөц хийгээд шавхагдашгүй баялаг сан хөмрөг бүхий соёл, урлагийн сонгодог уламжлалыг нэгдсэн бодлоготойгоор хөгжүүлэх, хадгалан хамгаалах, судлагаа шинжилгээг эрчимжүүлэх, сурталчлах зорилгоор “Баруун бүсийн соёлын сүлжээ” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Аймгийн соёл урлагийн байгууллагуудыг менежментийн хувьчилалд хамруулж, удирдлагын болон түрээсийн гэрээгээр ажиллуулах;

Гарах үр дүн: Хөдөөгийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний хүрээ өргөжиж, зах зээлийн нөхцөлд нийцсэн шинэ зохион байгуулалтанд шилжсэн байна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бүх нийтэд боловсрол эзэмшүүлэх мянганы хөгжлийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн сургалттай ахлах сургуулиуд байгуулах;
- Бүх шатны сургууль цэцэрлэгийн удирдлагын чадварыг дээшлүүлэх, ерөнхий боловсролын сургуулиудын сургалтыг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх, ерөнхий боловсролын сургуулиудын багш нарыг хөрвөх чадвартай болгон багшийг хөгжүүлж, тэднийг уран бүтээл хийх боломжоор ханган дэмжиж урамшууллыг бий болгох;
- Сургалтын агуулга стандартыг суралцагч бүрээр хангуулах, сургалтын дэвшилтэт аргуудыг хэрэгжүүлж амжилтанд хүрсэн багш нарыг шалгаруулах, сургууль завсардалт болон бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрэн арилгах, боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих;
- Хүүхдийн авьяас сонирхолыг хөгжүүлэх тэгш үйлчлэх, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Ажлын сургууль цэвэр, ардын авьяастныг түшиглэн зохион байгуулах, ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн цогцолбор байгуулах ажлыг судалж боловсруулан хэрэгжүүлэх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааны хүрээг өргөтгөх, үйлчилгээний чанар дээшлүүлэх, бага суурь бүрэн дунд боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх;
- Нэг ангид суух сурагчдын тоог улсын дунджид хүргэх, шинэ мэдлэг техник технологийн мэдээллээр хангах, аймгийн төвийн сургууль цэцэрлэг соёл байгууллагуудыг интернетэд холбох;

Гарах үр дүн: Сургууль завсардалт арилан, бүх шатны боловсролд хамрагдагсдын тоо нэмэгдэн хүн амын боловсролын түвшин дээшилнэ.

Тэргүүлэх зорилт 2. Албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Сургууль завсардсан хүүхэд залуучуудад боловсрол нөхөн эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чадвар дадлагад хамруулах;
- Хүн амын ерөнхий боловсролын түвшинг ахиулах, иргэдийг албан бус боловсролын үйлчилгээнд өргөн хамруулах;
- Иргэд АББ-ын тогтолцоонд аль боломжтой хэлбэрээр тасралтгүй боловсролоо дээшлүүлэх, сумын төвүүдэд Гэгээрэл төвийн үйлчилгээг жинхэнэ зорилгоор нь ажиллуулах тогтолцоог бий болгох;
- АББ олгоход шаардагдах техник хэрэгслийн хангамжийг сайжруулах;

Гарах үр дүн: Иргэд тохиромжтой хэлбэрээр бололцоотой хугацаандаа боловсрол эзэмших нөхцөл бүрдэнэ.

Тэргүүлэх зорилт 3. Боловсролын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, боловсрол эзэмших хүрээг өргөтгөх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ердийн галлагаатай хүүхдийн цэцэрлэг, ЕБС-уудын халаалтын асуудлыг шийдвэрлэх;
- Ховд аймгийн МСҮТ-ийг баруун бүсийн мэргэжилтэй ажилчин бэлтгэх, давтан сургах мэргэшүүлэх мэргэжил дээшлүүлэх, төв болгон бэхжүүлж, төв болон

сумдын сургуулийн дотуур байрыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэн ажиллуулах;

- Сургуулиудын техник тоног төхөөрөмжөөр нэн ялангуяа технологийн сургалтыг тоног төхөөрөмжөөр бүрэн хангах;
- Хөдөөгийн сургууль, цэцэрлэгийг байнгын цахилгааны эх үүсвэртэй болгох;
- АББ-ын гэгээрэл төвд сургалтын хөтөлбөр төлөвлөгөө холбогдох хэрэглэгдэхүүнийг компьютерийн сүлжээгээр түгээх нөхцөл бүрдүүлэх;

Гарах үр дүн: Бүх шатны боловсролын сургуулиудад сурч боловсрох ая таатай нөхцөл бололцоо бий болно.

Тэргүүлэх зорилт 4. Соёл урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Сум дундын соёлын байгууллага байгуулж ажиллуулах;
- Урлагийн авьяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулж дэмжих нэгдсэн төсөл хэрэгжүүлэх;
- Олон ястан, үндэстний түүх, урлаг, соёлын өвийг хадгалж хамгаалах, судлан шинжлэх, сурталчлах иж бүрэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Номын сан, архивын үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанаржуулах;

Гарах үр дүн: Соёл, урлагийн байгууллагуудын биеэ даан ажиллах оновчтой тогтолцоо бүрдэн, төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг, зохицуулалт сайжирна.

2.5. Хэрэглээний бүтцийг сайжруулах талаар

Үндэслэл: Ховд аймгийн хүн амын хэрэглээний бүтцэд сүүлийн жилүүдэд эерэг өөрчлөлт гарч байгаа боловч хэрэглээний нэр төрөл харьцангуй цөөн, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага зохих түвшинд хангагдахгүй байна .

Аймгийн төвийн чинээлэг иргэд болон алслагдсан сум, түүнчлэн хөдөөгийн ядуу, нэн ядуу иргэдийн хооронд хэрэглээний нэр төрөл, чанарын ялгаа ихээхэн зөрүүтэй байна.

Төв суурин газрын хүн амын хүнсний хэрэглээнд гурил, будаа, саахар, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг зонхилж байхад хөдөөгийнхний хэрэглээ мах, сүү, гурил, будаанаас төдийлэн хэтэрч чадахгүй байна. Ялангуяа ядуу, нэн ядуу өрхийн хэрэглээний түвшин үлэмж дор байна

Үйлдвэрлэл, үйлчилгээнд ч техник технологийн хоцрогдлоос үүдсэн үрэлгэн, зохисгүй хэрэглээ зонхилсоор байна Цэвэр, бохир усны шугам, цэвэрлэх байгууламжтай сумын төв бараг байхгүй байна .

Иймд хүн амын чинээлэг болон ядуу хэсгийн хэрэглээний түвшингийн зөрүүг багасгаж нэр төрөл, чанарт нь ахиц гаргах, үйлдвэрлэлийн хэрэглээг өөрчлөн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэг зохисгүй хэрэглээг халж, ухаалаг, чанартай, хэрэглээг бий болгон төлөвшүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн хэмжээнд хүнсний барааны хангамж, хэрэглээний бүтцийг өөрчлөн сайжруулж, хүнсний болон ахуйн шинэ зохистой хэрэглээг төлөвшүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээ, түүхий эдийн зах, үйлчилгээний цогцолборуудыг хөгжүүлэх;
- “Ногоон хувьсгал”, “Цагаан хувьсгал”, Хүнсний хангамж, аюулгүй байдал ба хоол тэжээл “ үндэсний хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд эрчимтэй хэрэгжүүлэх;
- Аймгийн хүн амын хоол хүнсний физиологийн нормыг нас ,хүйсний онцлогт нийцүүлэн шинэчлэн тогтоож мөрдөх;

- Баяжуулсан болон зориулалтын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх;
- Түүхий эдийн нөөцдөө тулгуурлан экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх;
- Хүн амын сүү,сүүн бүтээгдэхүүний 60хүртэл хувийг цөцгийн тосны 40хувийг аймгийн дотоодын үйлдвэрлэлээр хангах;
- Сумдын төв,өрхийн аж ахуйд тахиа, шувуу, гахайн аж ахуйг хөгжүүлэн өндөг, тахиа, гахайн махны хангамжийг сайжруулах;
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг урт хугацааны бага хүүтэй зээл /лизинг/-ээр урамшуулах арга хэмжээ авах;
- Хүн амын эмзэг хэсэгт хамрагдаж байгаа хүүхэд, жирэмсэн ба хөхүүл эхчүүдийг иоджуулсан давс, бичил бодисоор баяжуулсан гурилаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;
- Зохистой хэрэглээг бий болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөлжсөн болон сэдэвчилсэн сургалтууд тогтмол зохион байгуулах;
- Хүн амд иоджуулсан давс, баяжуулсан хүнс хэрэглэж сургах сургалтууд тогтмол зохион байгуулах;
- Хүн амын эрүүл мэндэд харш архи, тамхи болон стандартын бус бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах зорилгоор энэ талын сургалт, сурталчилгааг өргөтгөх;
- Хүн амд зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулахдаа боловсрол, соёл, харилцаа холбооны байгууллагуудыг өргөн ашиглах;

Гарах үр дүн: 2003 оны түвшинтэй харьцуулахад төмс, хүнсний ногооны хангамж 20 хувь, жимс жимсгэний хангамж 10 хувь, загас, загасан бүтээгдэхүүний 8 хувь, цөцгийн тосны хангамж 50 хувь өссөн байна.

Тэргүүлэх зорилт 2. Байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээг бий болгох үндэс суурийг тавина.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Дэвшилтэт техник,технологи бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийг аймаг сумын төвд байгуулах замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх;
- Түлшний харгана, модны хэрэгцээг багасган, хийн болон бусад төрлийн түлш ашиглах, барилга, модон эдлэлийн үйлдвэрлэлд өөр нэр төрлийн материал орлуулан хэрэглэхийг дэмжин урамшуулах;
- Ундны усны баталгаат эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- Үйлдвэрлэлийн хог хаягдлыг хоргүйжүүлэх ,халдваргүйжүүлэх ,хортой хаягдлыг устгах зориулалт бүхий үйлдвэрлэлийг шинээр бий болгон хөгжүүлэх;
- Хог хаягдал, бохир ус зайлуулах, устгах, ялган боловсруулах, цэвэршүүлэх төсөл шалгаруулан аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлэх;
- Үйлдвэрлэлийн болон хүн амын хэрэглээний явцад гарсан хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулж ашиглах;
- Орчныг бохирдуулагч нь илүү төлбөр төлөх зарчмыг тууштай хэрэгжүүлэх;

Гарах үр дүн: Орчин үеийн технологид суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл хөгжин үйлдвэрлэлийн хэрэглээ шинэчлэгдэх үндэс суурь тавигдсан байна.

Тэргүүлэх зорилт 3. Аймгийн төвийн гэр хорооллын хүн амын усан хангамжийн түвшинг дээшлүүлж, усны зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймаг сумын төвд цэвэр бохир усны системийн техник технологийг шинэчлэх зорилгоор аймгийн төвд цэвэр ус дамжуулах шугам тавих, гэр хорооллын усан хангамжийг сайжруулах;
- Эрдэсжилт өндөр болон хатуулаг ихтэй усны чанарт хяналт–шинжилгээ хийх, ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах;
- Стандартын шаардлага хангадаггүй ахуйн хэрэглээний усны эх үүсвэртэй төв, суурин газар, цэргийн ангид ус цэвэршүүлэх техник технологи нэвтрүүлэх;
- Хөдөө орон нутагт гүний худгийг сэргээн засварлаж, дундын эзэмшлийн гэрээ байгуулах замаар эзэнтэй болгож, хүн амын цэвэр усны хүртээмжийг сайжруулах;
- Найрлагын хувьд стандартын шаардлага хангасан цэвэр ус, рашаан савлах жижиг, дунд үйлдвэр байгуулахыг бүх талаар дэмжих;
- Дэвшилтэт техник, технологи бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийг аймаг сумын төвд байгуулах замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх;
- Усыг зохистой хэрэглэх, хадгалж хамгаалах талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг

тогтмол зохион байгуулах;

Гарах үр дүн: Хүн амын усан хангамжийн болон ундны усны эрүүл ахуйн стандартын шаардлага хангах түвшин мэдэгдэхүйц дээшлэнэ.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он) :

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн хүн амын хүнсний хангамж, хэрэглээний бүтцийг өөрчлөн сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх замаар аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, цөцгийн тосны үйлдвэрлэлийг өсгөн, дотоодын зах зээлд загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтмол нэмэгдүүлэх;
- Хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг 60-70 хүртэл хувиар өсгөх арга хэмжээ авах;
- Аж ахуйн нэгж өрхийн үйлдвэрлэлийг дэмжин хүнсний шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах;
- Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний барааны чанар, стандарт, эрүүл ахуйн үзүүлэлтийг өндөр нарийвчлалтай баталгаажуулдаг тогтолцоог бий болгох;
- Бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настны болон тусгай хоол хэрэглэдэг бүлгийн хүмүүсийн хоол тэжээлийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг бий болгох;
- Аймаг, сумын төвүүдэд бичил бодисоор баяжуулсан хоолны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, сургалтуудыг зохион байгуулах;

Гарах үр дүн: 2003 оны түвшинтэй харьцуулахад төмс, хүнсний ногооны хангамж 30 хувь, жимс жимсгэний хангамж 15 хувь, загас, загасан бүтээгдэхүүний 10 хувь, цөцгийн тосны хангамж 60 хувь өссөн байна.

Тэргүүлэх зорилт 2. Байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлд зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Түлшний мод хэрэглэхийг багасган байгалийн хий болон бусад төрлийн түлш хэрэглэх, барилга, модон эдлэлийн үйлдвэрлэлд өөр төрлийн материал орлуулан ашиглахад чиглэсэн дэвшилтэт технологийг дэмжин урамшуулах;
- Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хангамжийг сайжруулах чиглэл бүхий үйлдвэрүүдийг түлхүү дэмжих;

- Байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор энэ талын хяналтыг хүчтэй болгох арга хэмжээ авах;
- Бүсийн тулгуур төвийн хувьд аймгуудын хэмжээнд үйлдвэрлэлийн болон хэрэглээний явцад гарсан хог хаягдлыг төрөлжүүлэн дахин боловсруулах үйлдвэрүүд байгуулах;

Гарах үр дүн: 2015 он гэхэд үйлдвэрлэлийн хэрэглээний бүтэц, чанарт өөрчлөлт гарч, хүн амын эрүүл мэндэд хоргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл сайжирсан байна.

Тэргүүлэх зорилт 3. Төв суурин газрын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангах ажлыг сайжруулж, усан хангамжийн түвшинг дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төв, суурин газрын хүн амын ундны ба ахуйн хэрэглээний усны эх үүсвэрт ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, тохижуулах тохижуулах ажлыг сайжруулах;
- Аймаг сумдын ундны усны зарим шинэ эх үүсвэрийг судлан тогтоож, сумын ундны усны худгуудад цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулан, усны чанар, хангамжийг сайжруулах;
- Эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр ус савлан хот, хөдөөгийн иргэдийн эрэлт хэрэгцээг хангах ажлыг өргөтгөх;
- Усыг ариг гамтай хэрэглэх талаархи мэдээлэл, сурталчилгааг тогтмолжуулах;

Гарах үр дүн: Хүн амыг ариун цэвэр, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах боломж, нөхцөл сайжирна.

ГУРАВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ

3.1. Агаар мандлын хамгаалал

Үндэслэл: Үйлдвэрлэл, үйлчилгээнд агаар бохирдуулдаггүй өндөр үр ашигтай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, бохирдуулагч эх үүсвэрүүдийг цөөлөх, шаталт сайтай зуух, түлшийг өргөн хэрэглэх, хог хаягдлыг дахин боловсруулах, хот суурин газрыг зүлэгжүүлэх зэрэг ажлыг дэс дараатай хийж, тууштай хэвшүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Агаар мандалын чанар, төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналт шинжилгээ, мэдээллийн сүлжээг өргөтгөн, цэвэр агаартай давуу талаа хадгалах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Агаарын бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт хийж, хот суурин газруудын ус цаг уур, орчны шинжилгээний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх
- Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах;
- Шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх үйлдвэрлэл, үйлчилгээ болон барилга байгууламжийн төсөлд агаар мандалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж зөвшөөрөл олгох;
- Агаарын бохирдол үүсгэгч байгууллага, аж ахуйн нэгжийг хяналт шинжилгээнд тогтмол хамруулах;
- Гүйцэд шатдаг гэрийн зуухны технологи, утаагүй түлш нэвтрүүлэх замаар зуухнаас гарах утааг багасгах;

- Авто тээврийн хэрэгслээс гарч буй хорт бодис, угаарын хийн зөвшөөрөгдөх хэмжээ, стандарт мөрдөлтөд тавих мэргэжлийн хяналтын албадын хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хот суурингийн замыг цардах, ногоон байгууламжийг өргөтгөх замаар тоос дэгдэлтийг бууруулах;
- Хил дамжсан агаарын бохирдолтыг хамтран хянах, цаг алдалгүй мэдээлэл солилцох талаар хөрш орнуудын аймаг, муж, хотуудтай хамтран ажиллах;
- Агаар, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээний талаархи мэдээллийг сайжруулж, мэдээлэл ашиглах боломжийг нэмэгдүүлэх;
- Хог хаягдал, бохир усыг ил задгай хаях, шатаахыг бүрмөсөн зогсоох арга хэмжээ авах;

Гарах үр дүн: Ховд аймгийн хот, суурин газруудад агаарын бохирдлыг хянах үр нөлөө бүхий тогтолцоо бүрдэн, ялангуяа гэр хорооллын агаарын бохирдлын хэмжээ эрс буурна.

Тэргүүлэх зорилт 2. Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, агаар бохирдуулагчидтай хийх тэмцлийн арга хэлбэрийг боловсронгуй болгох.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн шингэн түлштэй цахилгаан станц, уурын зуухнуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- Сумын төв, суурингийн халаалтыг цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх;
- Гэр хорооллын айл өрхийн 70 хүртэл хувийг бүрэн шаталттай зуух, түлшээр хангах;
- Гэр хороололд байршилтай ердийн галлагаатай орон сууцуудыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг эхлүүлэх;
- Нам даралтын халаалтын зуухаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд бүрэн хамруулж, аймгийн төвүүдийн 1 дүгээр бүсийн дулаан халаалт, хэрэглэгчдийг төвлөрсөн халаалтын сүлжээнд хамруулах;
- Фреон 11, 12-оор ажилладаг хөргөгчийг үйлдвэр үйлчилгээ, ахуйн хэрэгцээнд ашиглахыг хориглох, хлор агуулаагүй гидрофторт нүүрс төрөгчөөр ажилладаг хөргөгч хэрэглэхийг дэмжих;
- Мэдээлэл, эрчим хүчний салбарт цахилгаан соронзон орны бохирдол багатай технологи нэвтрүүлэх;
- Ховд хот болон сумын төвүүдийн 1-р бүсийн цэцэрлэгжүүлэх талбайн хэмжээг 10 хувьд хүргэх;
- Шахмал түлш үйлдвэрлэхэд хувийн хэвшлийн оролцоог бүх талаар дэмжиж хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчин, хүний эрүүл мэнд, эдийн засагт учруулсан хохирлыг бохирдуулагч нь нөхөн төлөх, бохирдлыг багасгах зардлыг хариуцах эрх зүйн үндсийг бий болгож мөрдөх;
- Хог хаягдал ялган боловсруулах бүсийн чанартай үйлдвэр байгуулах;
- Химийн хорт болон цацраг идэвхт бодисын импорт, экспорт, тээвэрлэлт, хадгалалт, хэрэглээнд хяналт тавих тогтолцоог бий болгож мөрдөх;
- Оргоник бохирдуулагчын тооллого судалгааг гаргах;
- Хог хаягдлыг ялган, төрөлжүүлж байгаль халгүй аргаар зайлуулж, устгах ажилд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: Агаар мандлыг цэвэр ариун байлгах талаар аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг хариуцлага нэмэгдэж, бохирдлын хэмжээ буурна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Агаарын төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналтын хүрээг өргөтгөж, мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Агаарын бохирдол, агаарын төлөв байдалд тавих хяналтыг тогтмолжуулж, нарны хэт ягаан туяаг хэмжих хийх багаж, тоног төхөөрөмжийг аймгийн төвд суурилуулах;
- Сумын төвүүдийн Ус цаг уур, орчны шинжилгээний салбаруудын 50 хүртэл хувийг агаарын бохирдлын түвшинг хэмжих багаж, тоног төхөөрөмжөөр хангах;
- Эрчим хүчний системийг байгаль орчинд хал багатай тоног төхөөрөмжөөр шинэчлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Үйлдвэрлэлийн хаягдлыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдалгүй болон дахин боловсруулах техник, технологи нэвтрүүлэх;
- Түлшний шинэ эх үүсгэвэр бий болгох, түүнийг тээвэрлэх, хадгалах, үр ашигтай хэрэглэх талаар дотоод, гадаадын туршлага, санаачилгыг идэвхтэй дэмжих;
- Агаар бохирдуулагчтай хийх тэмцлийн хүрээг өргөтгөж, энэ чиглэлийн төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх;

Гарах үр дүн: Агаарын чанар, төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналт сайжирч, аймгийн хэмжээнд мэдээллийн сүлжээ бий болно.

Тэргүүлэх зорилт 2. Аймгийн төвийн агаарын бохирдлыг эрс бууруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн төвийн айл өрхийн 80 хүртэл хувийг бүрэн шаталттай зуух, түлшээр хангах;
- Гэр хороололд байршилтай ердийн галлагаатай орон сууцуудыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үргэлжлүүлэх;
- Тээврийн хэрэгслээс агаарт гаргах төрөл бүрийн хорт хийг бууруулах зорилгоор аймгийн төвд “Техник оношлогооны төв” байгуулах;
- Аймгийн төвийн II бүсэд хамаарах нам даралтын зуух бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийг байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд хамруулж, боломжтой цэгүүдийг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг дэс дараатай гүйцэтгэх;
- Төв суурин газрын уур амьсгалыг зөөлрүүлэх зорилгоор аймаг, сумын төвүүдийн 1-р бүсийн цэцэрлэгжүүлсэн талбайн хэмжээг 30 хувьд хүргэх;
- Шахмал түлш үйлдвэрлэх хувийн хэвшлийн хүрээг улам өргөтгөх;

Гарах үр дүн: Агаар мандлын хамгаалалтын түвшин дэлхийн жишигт ойртоно..

3.2. Газрын нөөцийн ашиглалт, хамгаалал

Үндэслэл: Ховд аймаг нь 7606.0 мянган га нутаг дэвсгэртэй бөгөөд үүнээс 6577.8 мянган га нь хөдөө аж ахуйн зориулалтын газар, 33.3 мянган га хот суурингийн эдэлбэр газар, 16.2 мянган га нь тусгай хэрэгцээний газар, 644.3 мянган га ой, 255.2 мянган га нь нуур гол, горхи 4.6 мянган га улсын нөөц газар байна. Ховд аймгийн 10 сумын нийт 1664.8 мянган га талбай нутаг дэвсгэр тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан нь аймгийн нийт нутаг дэвсгэрийн 21.9 хувь, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 8.1 хувийг тус тус эзэлж байна.

Харин одоогоор орон нутгийн тусгай хамгаалалтанд 256.9 мянган га талбайг бүхий газар нутгийг аваад байна.

Цаашид Алаг Тэхт уул, Сутай уул, Бөөрөгийн нуруу орон нутгийн хамгаалалтанд авч аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулахаар төлөвлөж байна. Гэвч газрын ашиглалт хамгаалттай асуудлууд хуримтлагдсаар байна. Сүүлийн жилүүдэд малчид худаг устай өвөлжөө хаваржаа тойрон бөөгнөрсний улмаас бэлчээрийн талхагдал нэмэгдэж, авто тээврийн хэрэгслийн

олон салаа зам газрын хөрсийг сүйтгэн бэлчээрийг ихээхэн хомсдуулжээ. Мөн худаг усаа эвдэж сүйтгэсний улмаас их хэмжээний бэлчээрийг ашиглаж чадахгүйд хүрчээ. Ашигт малтмал олборлолттой холбоотойгоор хөрсний эвдрэл ихсэх хандлагатай болов.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Газрын нөөцөд экологи-эдийн засгийн үнэлгээ хийж, газрын ашиглалт, хамгаалал, мэдээллийн үйл ажиллагааг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн газар ашиглалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Газар ашиглалтын төлөв байдал, үржил шимийг дээшлүүлэх, түүнчлэн стандартын холбогдолтой мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх оновчтой тогтолцоог бий болгох;
- Газрын нөөцийн менежментыг сайжруулж, газар зохион байгуулалтын орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;

Гарах үр дүн: Газар ашиглалтыг шинжлэх ухааны үндэстэй сайжруулж ашиглах нөхцөл бүрдэнэ.

Тэргүүлэх зорилт 2. Бэлчээрийн талхагдалын хэмжээг 30 хувь, хөрсний эвдрэлд орсон талбайн хэмжээг 10 хувь бууруулж, бэлчээрийн зүй зохистой ашиглалтыг 50 хувь нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Мал өсгөх, үүлдэр угсааг сайжруулах зорилтуудыг бэлчээрийн даац, ус, тэжээлийн хангамж зэрэгтэй уялдуулан оновчтой төлөвлөн зохицуулж, арга механизмыг боловсронгуй болгох;
- Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах;
- Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайн хөрсний эвдрэлийг зогсоох, олон наст ургамлын үр тарих, бэлчээрийг нөөцөд шилжүүлэх арга хэмжээ авах;
- Инженерийн хийцтэй уст цэгийг засварлах, шинээр гаргах ажлыг жил бүр хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж бэлчээр, усжуулалтын түвшинг дээшлүүлэх;
- Үлийн цагаан оготны тархалтыг зогсоох, хор хөнөөлийг багасгах төрөл бүрийн дэвшилтэт арга хэлбэрүүдээс орон нутагт туршиж, сонгон нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;
- Тариалан эрхлэгчдэд газрыг өмчлүүлж, түрээслүүлэх зэргээр хөрсний эвдрэлийг бууруулах зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, тариалангийн талбайг тойруулж ойн зурвас тарьж ургуулах;
- Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллүүдийг арилгах арга хэмжээ авах;
- Ашигт малтмалын ордыг ашиглах аж ахуйн нэгжийн зураг, төсөл, техникийн бичиг баримтанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ашиглах зөвшөөрөл олгох;
- Ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах төлөвлөгөөт зардлын 50 хувийг сумын төсөвт шилжүүлдэг журам тогтоох;

Гарах үр дүн: Бэлчээрийн даац хэтрэлт болон тариалангийн хөрсний эвдрэлийг бууруулах болон газрыг оновчтой ашиглах хандлага давамгайлна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Газар ашиглалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Газар ашиглалтын менежментийг сумдын түвшинд нэвтрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хөрс хамгаалах дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөгүй бордоог хэрэглэх;
- Худаг ус гаргах ажлыг сайжруулах замаар бэлчээрийг усжуулж, бэлчээр ашиглалтад эдийн засгийн оновчтой хөшүүргүүдийг хэрэглэх;
- Техник-технологийн оновчтой бодлого хэрэгжүүлэх замаар нэг га-гаас авах ургацын хэмжээг 20 центнерээс доошгүй хэмжээнд хүргэх;
- Тариалан эрхлэгчдэд газрыг өмчлүүлэх, түрээслүүлэх зэрэг аргаар тариалангийн хөрсний ашиглалтыг сайжруулж, эвдрэлийг зогсоох;
- Ашигт малтмал олборлолттой холбоотой хөрсний эвдрэлийг арилгах;
- Авто замын тогтсон сүлжээг бий болгон цардмал зам, сайжруулсан зам тавьж олон салаа замыг багасгах;
- Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж 2015 онд нийт нутгийн 25 хувьд хүргэх;
- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх замаар хамгаалалтын ажиллагааны бие даасан тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх;
- Хилийн дагуу байгаа Их говийн дархан цаазат газрын Б хэсэг, Булган голын байгалийн нөөц газрыг хамгаалах талаар БНХАУ-ын зэргэлдээ аймаг, мужтай гэрээ хэлцэл хийх ажлыг зохион байгуулах;

Гарах үр дүн: Бэлчээрийн даацын хэтрэлт, тариалангийн хөрсний эвдрэл багасч, газар ашиглалт сайжирна.

3.3. Усны нөөцийн ашиглалт, хамгаалал

Үндэслэл: Аймгийн нутаг дэвсгэр дээр гадаргын усны горимыг судлах, хяналт шинжилгээний 7 харуул Алтай, Булган, Дөргөн, Мөнххайрхан, Мянгад, Үенч, Жаргалант сумуудад ажилладаг бөгөөд гол усны урсацын дийлэнхийг бүрдүүлэгч Ховд, Буянт, Булган, Бодонч, Үенч, Цэнхэр голуудын жилийн дундаж урсацыг сүүлийн 4 жилээр авч үзэхэд хамгийн бага урсацтай жил нь 17.2 м³/сек байсан ба 2002 онд 19.5 м³/сек болж өссөн байна. Харин Буянт, Үенч голууд жил бүр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн нийт нутгийг хамруулан хийсэн гадаргын усны тооллогын дүнгээр 200 гаруй гол горхи, 200 гаруй нуур, цөөрөм, 460 гаруй булаг шанд, рашаан ус байгааг тогтоолоо. Сүүлийн жилүүдэд манай аймгийн нутаг дэвсгэрт 7 гол, 10 булаг, 4 нуур цөөрөм ширгэсэн байна.

Ундны ус нь эрдэжилт, хатуулаг ихтэй Дөргөн, Дуут сумдад ус зөөлрүүлж, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулж, хүн амын ундны усны чанар, стандартын шаардлага хангасан усаар хангагдаж байгаа бөгөөд цаашид Дарви, Чандмань, Цэцэг сумдад эдгээр төхөөрөмжийг суурилуулахаар төлөвлөж байна.

Аймгийн нутаг дэвсгэрт 2133 худаг тоологдсоны 300 орчим нь гүний өрмийн, 450 гаруй нь богино яндант, 150 нь бетон хашлагат, 1200 гаруй нь энгийн уурхайн худаг байна.

Усны бохирдол харьцангуй бага байгаа боловч, усны шинэ нөөц илрүүлэх, оновчтой ашиглах шаардлагатай байна. Цаашид бэлчээрийг усжуулах, усалгаатай газар тариалан эрхлэх, зарим төв суурин газрын ундны усны чанарыг сайжруулах зэрэг олон чухал асуудлыг шийдэх хэрэгтэй байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглаж, хамгаалалыг нь сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Гадаргын ус, уст цэгийн үзлэг тооллого явуулж, усны хангамжийн түвшинг шинэчлэн тогтоох;
- Төв, суурингийн усны бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;
- Буянт гол, Хар-Ус нуурын бохирдлын байдалд мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх;
- Төв, суурингийн хүн амын болон үйлдвэрлэлийн усны хэрэглээний нормыг орон нутгийн онцлогт тохируулан шинэчлэн тогтоох;
- Төв суурин газрын ундны усны эх үүсвэрийг баталгаажуулах, ундны усыг иоджуулах, цэнгэгжүүлэх арга хэмжээ авах;
- Хүн амын ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх бага оврын тоног төхөөрөмжийг говийн сумдад нэвтрүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх;
- Хүний биед ашигтай, ховор элемент бүхий рашаан болон цэнгэг усыг савлаж, зах зээлд нийлүүлэх;
- Бэлчээрийг усжуулж, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглах;
- Бэлчээрийн даац сайтай нутгуудад уст цэгийн хайгуул хийж, усжуулах арга хэмжээ авах;
- Инженерийн хийцтэй худгийг сэргээн засварлах болон шинээр байгуулах;
- Мөнххайрхан ууланд мөстөл судлалын харуул шинээр байгуулж, Цамбагарав уулын мөстөл судлалын харуулыг өргөтгөж өртөө байгуулах;

Гарах үр дүн: Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах боломж нөхцөл бүрдэн эрүүл ахуйн шаардлага хангасан усны хэрэглээг нэмэгдүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалж, аймгийн хэмжээнд усны зохистой хэрэглээг хангах арга хэмжээ авах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн усны нөөцийг оновчтой ашиглах, хамгаалах хяналтын бүтэц бий болгох;
- Усны эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, рашааны эхийг тохижуулан усны нөөцийн нөхөн сэргээх чадварыг сайжруулах арга хэмжээ авах;
- Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар аймгийн төвийг бүрэн хангах;
- Аймгийн төвийн цэвэр усны шугам сүлжээг сольж, мөн гэр хорооллын айлуудын ундны усны хангамж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах;
- Гол, горхины гольдролыг эвдрэлээс хамгаалах арга хэмжээ авах;
- Уст цэг, гадаргуугийн усанд ариун цэвэр, эрүүл ахуйн бүс тогтоох, усны чанар, бохирдолтод тогтмол шинжилгээ хийх журамд шилжих;
- Аймгийн төвийн ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
- Гарсан бохирыг эрүүл ахуй, байгаль орчинд халгүйгээр арилгах шинэ технологи нэвтрүүлэх;
- Аймгийн төвд ус ашиглалтыг бүрэн тоолууржуулах;
- Томоохон усан сан байгуулах, бороо, цасны усыг ашиглах төслүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлэх;
- Томоохон гол, мөрний ай савыг хамгаалах зөвлөл байгуулах;
- Ундны ус нь эрдэсжилт хатуулаг ихтэй Дарви, чандмань, Цэцэг, Эрдэнэбүрэн сумдад ус зөөлрүүлж, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах;
- Хүний биед ашигтай ховор элемент бүхий рашаан усны эхийг хамгаалах, тохижуулах ажлыг хэрэгжүүлэх;

Гарах үр дүн: Усны нөөцийг шинэ эх үүсвэрүүдээр сэлбэн оновчтой ашиглах, хамгаалах системд шилжинэ.

3.4. Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал

Үндэслэл: Манай аймгийн 0.85% буюу 644.4 мян.га талбай ойн сан бүхий нутаг эзэлнэ. Үүний 352 га талбайг улиас, 3,8 мянган га талбайг бургас, 3400 га талбайг хар мод, 40 мянган га талбайг харгана, 516.5 мянган га талбайг заг, 149 га талбайг хус, 2,7 мянган га талбайг чацаргана, бусад нь таримал ой эзэлж байна.

Харин жил бүрийн ойжуулалт, ойн арга хэмжээний хүрээнд 200-250 га талбайд ойжуулалт хийж, Ногоон хэрмийн үндсэн зурвасыг 2005 онд 42 га-д, 2006 онд 30 га талбайд хийсэн байна. Ойн сан бүхий газар харьцангуй багатай учир цаашид ойг нөхөн сэргээх, хамгаалах, ойжуулалт, Ногоон хэрэм хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Ой болон ургамлын нөөц багасахад хөнөөлт мэрэгч, шавьж багагүй нөлөөлж байна. үүний улмаас газар нутаг ургамалгүйжиж, чийгний ууршилт нэмэгдэн цас хунгарлалт багасч цөлжилтөд нэрвэгдэх аюул нүүрлэж эхлэв. Иймд ойг хамгаалах, ашиглалтад нь тавих хяналтыг сайжруулах, нөхөн сэргээх, ухаалаг хэрэглээг төлөвшүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Ойн нөөцийг хамгаалах цогцолбор арга хэмжээ авч, нөхөн сэргээлтийг идэвхжүүлж, ашиглалтад нь тавих хяналтыг хүчтэй болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Аймгийн ойн нөөцийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээ хийлгэх, нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Аймгийн ойн сангийн мэдээллийн сан, мониторингийн сүлжээ байгуулах
- Ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангах;
- Жил бүр нийтээр мод тарих өдрийг тогтоож, хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, авто замын дагуу ойн зурвас байгуулах арга хэмжээ авах;
- Заган ойжуулалт хийх, үр бэлтгэх, ойжуулсан талбайг хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналтын дор гүйцэтгэх;
- Ойг нөхөн сэргээх, түүний дагалт баялгийг бүрэн боловсруулан ашиглахад гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Хот, суурин газрын орчмыг ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажлыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авах;
- “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд олон нийтийг оролцуулж, бүс нутгийн байгаль цаг уурын нөхцөлд зохицон ургадаг тарьц суулгацын нөөцийг бий болгох;
- Ойжуулалт, Ногоон хэрмийн зурвас байгуулахад шаардлагатай тарьц суулгацын нөөцийг бий болгох зорилгоор бүс нутгийн байгаль цаг уурт зохицсон таримлын төрлөөр мод үржүүлгийн талбай байгуулах;
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байнгын эргүүл ажиллуулах, түймэр унтраах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах;

Гарах үр дүн: Ойн нөөцийн хамгаалалт сайжирч, ойжуулалт, нөхөн сэргээлт ашигласан талбайн хэмжээнд хүрнэ.

Тэргүүлэх зорилт 2. Ойг түймэр, хортон шавьж, мэрэгчдээс хамгаалах, хохирлыг арилгах, эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээ авах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ойн хортон шавьж, өвчинтэй биологийн болон байгальд халгүй бусад аргаар тэмцэх ажлыг өргөжүүлэх;
 - Ойн түймрээс урьдчилан сэргийлэх, сурталчилгаа хийх, түймэр унтраах ажилд мэргэжлийн хүмүүс сургаж бэлтгэн, багаж хэрэгслэлээр хангах;
 - Байгалийн нөөц ашигласны болон орчныг бохирдуулсны төлбөрийн орлогын тодорхой хувийг ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
 - Ой нөхөн сэргээлтийн ажлыг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэн урамшуулж, энэ талын сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах;
- Гарах үр дүн:** Ой хамгаалах, нөхөн сэргээх, үр дүнтэй, оновчтой систем бий болно.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Ойг хамгаалах, ашиглах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ойн нөөцийн нөхөн сэргээлтийг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Ойг хамгаалах, ашиглахтай холбоотой хууль, тогтоомж, журмыг боловсронгуй болгох;
- Ойн экологийн тэнцвэрт байдал, нөхөн ургах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлэхгүй мод бэлтгэлийн шинэ технологийг ой, ургамалжилтын онцлогт тохируулан боловсруулж нэвтрүүлэх;
- Ой мод ашигласны төлбөрийн тодорхой хэсгийг ойг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах;
- Ойн нөхөн сэргээлтийн ажлыг эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэн урамшуулах;
- Жил бүр ойжуулалт, ойн арга хэмжээг зохион байгуулж, ойн хортон шавьжтай тэмцэх, устгах ажлыг өргөтгөх;
- Бургас, улиас, заган ойг хамгаалах, нөхөн сэргээх ажилд нутгийн иргэдийг өргөнөөр татан оролцуулах, гэрээгээр эзэмших, хамгаалах, нөхөн сэргээх ажилд дэмжлэг үзүүлэх;

Гарах үр дүн: Ойн нөөцийн ашиглалт, хамгаалал хөгжилтэй орнуудын түвшинд ойртож, оновчтой тогтолцоо бүрдэнэ.

3.5. Цөлжилт, гантай хийх тэмцэл

Үндэслэл: Ховд аймгийн газар нутгийн ихэнхи хэсэг нь байгалийн хуурай, хуурайвтар бүсэд оршдог бөгөөд бүсийн байгаль орчныг доройтуулж, байгалийн нөөц, түүний дотроос биологийн нөөцийг хомсдуулж байгаа хүчин зүйлийн нэг нь цөлжилт юм. Цаг уурын дулааралт, хур тундасны жигд биш тархалт, бэлчээрийн талхагдал, газар тариалан, хот суурин газрын хөрсний элэгдэл, гангийн давтамж зэргээс шалтгаалан цөлжилт эрчимжих хандлагатай болжээ. Иймд экологийн энэхүү эмзэг асуудлыг онцгой анхаарч, дотоод гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн цөлжилттэй хийх тэмцлийг шинэ шатанд гаргах шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Элсний нүүдлийг сааруулж, ургамал нөмрөгийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөгөөтэй хэрэгжүүлж эхлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Баруун бүсийн хэмжээнд бусад аймгуудтайгаа хамтран цөлжилтийн шалтгаан, үр дагаварыг судлан тогтоож, түүнтэй тэмцэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Элсний нүүдлийг сааруулах, улмаар зогсоох зөв менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- Элсний нүүдлийг зогсоох, говь, цөлийн урагмалжлыг нөхөн сэргээхэд ашиглаж болох ургамлуудыг (заг, жигд, хайлаас, харгана, бүйлс, хотир гэх мэт) туршин үзэж, тодорхой үе шаттайгаар сонгон тариалах;
- Хот суурин газрын орчим мал ихээр бөөгнөрч бэлчээр талхлагдахаас урьдчилан сэргийлэх газар зохион байгуулалт, ашиглалтын оновчтой бодлого явуулах;
- Малчдыг шахмал түлш болон бусад төрлийн түлшээр хангах арга хэмжээг зохион байгуулалттай хэрэгжүүлэх;
- Элсэн хөрс тогтоох талаар туршлагажсан орнуудын туршлагыг судалж нэвтрүүлэх;

Гарах үр дүн: Цөлжилтийн эрчийг сааруулах бааз суурь бий болно.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Цөлжилттэй хийх тэмцлийг эрчимжүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Газрын элэгдэл, эвдрэл, бэлчээрийн хомсдол, хөрсний үржил шимийн доройтол, элсний нүүдэл, хуурайшилт, цөлжилтийн явцын талаар мэдээллийн нэгдсэн сан байгуулах;
- Ховд хотын ХААИС-ийн салбар сургууль зэргийг түшиглэн говь цөлийн ургамлын үржүүлэг хийх Ботаникийн цэцэрлэг байгуулах;
- “Ногоон хэрэм” хөтөлбөртэй уялдуулан говь, хээрийн бүсийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэн, ойн зурвас байгуулах;
- Аймгийн нийт сумдыг цөлжилт, элсний нүүдэл, гантай тэмцэх мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах;

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд элсний нүүдлийг сааруулж, цөлжилтөөс хамгаалах оновчтой тогтолцоо бүрдэнэ.

3.6. Биологийн төрөл зүйлийн хамгаалал

Үндэслэл: 2000 онд батлагдсан “Амьтны аймгийн тухай” Монгол улсын хуулиар “нэн ховор” ангилалт 26 зүйл амьтан оруулсны 17 зүйл нь буюу 65.4 хувь нь Ховд аймгийн нутагт дэвсгэрт байна.

Тус аймгийн нутаг дэвсгэрт цөлийн, цөлжүү, уулын хээрийн болон хээржүү цөлийн ургамалжилт зонхилж, ойн ургамалжилт хамгийн бага тархах ба голын хөндийг дагасан хус, улиас, бургас сөөгөн ойн шугуйтай. Ургамлын аймгийн хувьд 89 овгийн 381 төрөлд хамаарах 1,1 мянган зүйл цоргоц ургамал хамаарагддаг.

Мөн нэн ховор, ховордож байгаа 34 зүйлийн ургамал байгаа бөгөөд 22 зүйл ургамал нь Монгол улсын Улаан номонд бүртгэгдсэн байна. Сүүлийн жилүүдэд энэ бүс нутгийн байгалийн баялгийг зүй бусаар ашиглах явдал ихэслээ. Нэн ялангуяа дэлхийд ховордсон улаан номонд орсон амьтныг агнаж устгах явдал гарсаар байна. Иймд аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах асуудал нэн чухал байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Ховд аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах эрх зүй, зохион байгуулалтын таатай орчин бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Экологи-эдийн засгийн үнэлгээ хийх үндсэн дээр аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - Байгаль орчны доройтол, ургамал амьтны хорогдолтой тэмцэх, нөхөн үржүүлэх, нутагшуулах ажлыг явуулахдаа үндэсний уламжлалт аргуудыг дэлхийн дэвшилтэт арга, технологитой хослуулах;
 - Орон нутгийн байгаль хамгаалах төрийн бус байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх;
 - Байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хадгалах, биологийн төрөл зүйлийг хайрлан хамгаалах үзэл бодлыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх;
 - Сум бүрийн газар ашиглалтын төлөвлөлтөд биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг хамгаалах асуудлыг тусгаж хэвшүүлэх;
 - Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;
 - Биологийн төрөл зүйлийг хамгааллахад эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэж хэвшүүлэх;
 - Аймгийн амьтан, ургамал, ой, бичил биетний мэдээллийн санг бүрдүүлэх;
 - **Гарах үр дүн:** Аймгийн биологийн төрөл зүйлийн хэвийн өсөлтийг хангах суурь нөхцөл бүрдэнэ.
 - **Тэргүүлэх зорилт 2.** Аймгийн биологийн зарим төрөл зүйлийг оновчтой ашиглаж, хамгаалах.
 - **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**
 - Ховор ан амьтан үржиж төллөдөг, нүүдлийн болон суурин амьдардаг шувууд өндөглөдөг болон ургамал бүхий газар нутгийг нөөцлөн үлдээх арга хэмжээ авах;
 - Хяргас, Хар-Ус, Хар, Дөргөн нуурт загас үржүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах;
 - Ан амьтны нөөц ашигласнаас олсон орлогыг байгаль хамгаалагч, ашиглагч этгээд, мөн нутгийн иргэдэд зохистой зөв хуваарилдаг журам хэрэгжүүлэх;
- Гарах үр дүн:** Байгалийн баялгийг экологид нөлөөлөхгүйгээр зүй зохистой ашигладаг болно.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Аймгийн биологийн төрөл зүйлийн ашиглалт, хамгааллыг сайжруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн хөгжлийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээрх судалгааг өргөтгөж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Байгаль орчны доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдлыг хязгаарлан зогсоох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ач холбогдол бүхий газар нутгийг УТХГН-ийн сүлжээнд хамруулах;
- Байгаль экологийн өвөрмөц тогтоцтой, ховор амьтан, ургамлын нөөцтэй Мөнххайрхан уул, Алтан Хөхийн нуруу, Бөөрөгийн нуруу, Сутай уул, Алагтэнт уул, Гурван Сэнхэрийн агуй зэрэг газруудыг улсын болон орон нутгийн хамгаалалтанд оруулах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэх;
- Аймгийн байгалийн унаган төрх, үзэсгэлэнт тогтцуудыг түшиглэн байгалийн хүрээлэн байгуулах ажилтай нягт уялдуулах;
- Биологийн төрөл зүйлийн ач холбогдлын талаарх хүн амын мэдлэг, мэдээллийг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг өргөтгөх;

- Дархан цаазат газар ба байгалийн цогцолбор газрын орчны бүсүүдэд байгаль орчинд халгүй аж төрөх альтернатив хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлж эхлэх;
- Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ховор ан амьтан, ургамлын судалгаа гаргаж, хэвийн өсч үржих нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг өргөтгөх;
- **Гарах үр дүн:** Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ бүрэлдэн, ашиглалт хамгаалал эрс сайжрана.

3.7. Байгалийн гамшгаас сэргийлэх, хохирлыг бууруулах талаар

Үндэслэл: Зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, мөндөр, хүйтэн бороо орох, үер, ган, хүн мал ургамал, амьтны гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр зэрэг байгалийн гэнэтийн үзэгдэл, гамшиг үе үе тохиолдож мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл болон эдийн засаг, байгаль орчинд багагүй хохирол учруулсаар байна.

Байгалийн гамшигийг судлах, урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон гамшигтай тэмцэх, учирсан хохиролыг нь багасгах чиглэлээр олон улсын байгууллагуудаас дэмжлэг туслалцаа үзүүлж, удирдлага зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авдаг боловч гамшигийн хохирлын хэмжээ тууштай буурахгүй байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

Тэргүүлэх зорилт 1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах оновчтой тогтолцоог бий болгох.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг 2006 оны түвшингээс 25 хувиар нэмэгдүүлэх;
- Цаг уур, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшигийн мэдээллийн төвийг байгуулан чадавхийг бэхжүүлэх;
- Аюулт үзэгдлийг урьдчилан тооцоолох, олон нийтэд мэдээлэх чиглэлээр аймаг, сумын түвшинд цаг уурын албадын чадавхийг дээшлүүлэхийн зэрэгцээ энэ чиглэлээр хашир туршлагатай малчдын зөвлөл байгуулж ажиллуулах;
- Ой, ургамлын хортон шавьжийн голомт, нүүдэл, хүн, мал амьтны гоц халдварт өвчний аюул гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээртэй тэмцэх хор уршгийг арилгах, ургамал, хорио цээр, хүн, мал эмнэлгийн албаны чадавхийг дээшлүүлэх;
- Газар хөдлөлийн станцын хяналтын тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, хот, суурин бүрийг газар хөдлөлтийн хүчийг тооцон барилгажуулах;
- Мэргэжлийн хяналтын лабораторуудыг орчин үеийн техник хэрэгслэлээр бэхжүүлж, мэргэжилтнүүдэд оношлогоо шинжилгээний орчин үеийн мэдлэг эзэмшүүлэх;
- Хот, суурины шаардлагатай цэгүүдэд голын эргийн хамгаалалт барих;
- Малын өвс тэжээлийн 1 сар хүртэл хугацааны нөөц бий болгох;
- Байгалийн гамшиг тохиолдсон үед хохирлыг зохих хэмжээгээр нөхөх зорилгоор байгууллага, иргэдийг эд хөрөнгийн болон бусад, амь насны даатгалд хамруулах ажлыг сайжруулах;
- Хур тундасны хэмжилтийг багуудад хийх боломж бүрдүүлэх;
- Байгаль цаг уурын гамшигийн аюулыг бууруулах, болзошгүй гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх нөөц бололцоо техникийн хүчин чадлыг бий болгох;

- Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн менежментийг боловсронгуй болгох, ард иргэдийг аюулгүй амьдрах арга ухаанд сургаж дадлагажуулах, эрсдэл эмзэг байдлыг бууруулах;
- Аймгийн Онцгой байдлын хэлтэст мэдээлэл хүлээн авах станц суурилуулж, автомат дохиолол бүхий газруудтай шууд холбогддог болгох;
- Гамшгийг урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх тогтолцоог бий болгох хиймэл дагуулын сүлжээтэй шууд холбогдох;

Гарах үр дүн: Аймгийн хэмжээнд байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах чадавхи дээшилнэ.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

Тэргүүлэх зорилт 1. Байгаль, цаг уурын онц аюултай үзэгдэгдлээс урьдчилан сэргийлэх оновчтой тогтолцоо бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг 2006 оны түвшингээс 50 хувиар нэмэгдүүлэх;
- Гамшгаас сэргийлэх, хор хөнөөлийг бууруулах, гамшигтай тэмцэх талаарх менежментийг сайжруулах;
- Байгалийн гамшигтай тэмцэх өвс тэжээл, хүнс, эмнэлгийн анхны тусламжийн байнгын нөөцтэй болох;
- Байгалийн гамшгийн талаарх хүн амын мэдлэгийг байнга дээшлүүлэх зорилгоор жил бүр тусгай сургалт зохион байгуулах, эн түрүүнд шаардлагатай багаж хэрэгслээр хангах ажлыг тогтмолжуулах;
- Байгалийн гамшиг тохиолдсон үед хохирлыг бүрэн нөхөх зорилгоор байгууллага, иргэдийг эд хөрөнгийн болон амь насны даатгалд бүрэн хамруулах;
- **Гарах үр дүн:** Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулах, шуурхай арилгах бүсийн хэмжээний оновчтой тогтолцоо бүрдсэн байна.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АРГА ХЭРЭГСЭЛ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын оновчтой удирдлага, зохион байгуулалтаар хангах, түүний хэрэгжих дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө санхүүгийн шаардагдах эх үүсвэрийг олж, оновчтой ашиглах, олон нийтийн оролцоог өргөтгөх нь Ховд аймгийн хөгжлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл мөн.

4.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл

- Бүсийн зөвлөл, аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр оновчтой уялдуулах;
- Засгийн газрын түвшинд яамд, агентлагуудын энэ талын хамтын ажиллагааг оновчтой уялдуулан зохицуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргын Тамгын газар, бүсийн зөвлөл, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжих оновчтой арга хэрэгсэл, механизмыг бий болгох;
- Улсын жил жилийн төсөв, дунд хугацааны төлөвлөлтийн бусад баримт бичгүүд, эдийн засаг, нийгмийн салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг аймгийн хөгжлийн энэхүү хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр харьцангуй богино хугацааны төрөлжсөн хөтөлбөр, мастер төлөвлөгөө төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;

- Макро түвшний нэгжүүдийн үйл ажиллагааг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлтэй оновчтой уялдуулах;
- Хувийн хэвшлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд эдийн засаг, эрх зүйн оочин бий болгох;
- Статистикийн бүртгэл, мэдээллийг үзүүлэлтийг хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөхөд нийцэх чиглэлээр боловсронгуй болгох;
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийг улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байх;
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, давуу талуудаа бататган, сөрөг талуудаа саармагжуулан, алдаа дутагдлаа засч байх;

4.2. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл

- Эдийн засаг, санхүүгийн хөшүүргүүдийн тусламжтайгаар экспортын чиглэлтэй үйлдвэрлэлийг түлхүү дэмжих;
- Өндөр хөгжсөн болон түргэн хурдацтай хөгжиж байгаа орнуудын энэ талын туршлагыг бүтээлчээр хэрэглэх;
- Хүн ардынхаа оюуны чадавхид тулгуурлан хөгжих бодлогыг тууштай баримтлаж, боловсролын салбарт тэргүүлэх ач холбогдол өгч, өндөр хөгжилтэй орнуудад нарийн мэргэжлийн боловсон хүчин, инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх;
- Эдийн засгийн өсөлтийг өндөр технологид суурилсан уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эрчимтэй өсөлтөөр хангах чиглэл баримтлах;
- Экспортыг нэмэгдүүлэх салбар, үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалтаар дэмжих;
- Үйлдвэрлэл, үйлчилгээг татвар, гаалийн бодлогоор оновчтой дэмжих;
- Өндөр технологи нутагшуулахыг бүх талаар дэмжих;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Дотоодын хуримтлалыг нэмэгдүүлж, оновчтой төвлөрүүлэн ашиглах механизмыг бий болгох;
- Санхүү, үнэт цаас, хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх;
- Үйлдвэрлэл, технологийн парк, эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсийг эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах арга хэрэгсэл болгох;

4.3. Олон нийтийн оролцоо

- Шийдвэр гаргах бүх түвшинд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг сайжруулах;
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэдийг өөрсөдтэй нь холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд өргөнөөр оролцуулж тэдгээрийн эрх ашгийг тууштай хамгаалах;
- Аймгийн хүн амын 50 гаруй хувийг эзэлдэг эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхи, хөгжилд оролцох хүсэл эрмэлзлийг идэвхтэй дэмжих;
- Аймгийнхаа тулгамдсан асуудал, нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд залуучуудыг өргөн оролцуулах оновчтой хөшүүрэг бий болгох;
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлаар бодлого боловсруулах, шийдвэр гаргахад бизнес эрхлэгчдийг өргөнөөр оролцуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Төрийн бус байгууллагуудын гүйцэтгэж чадах олон чиг үүргийг тэдэнд шилжүүлэх замаар төрийн байгууллагуудын орон тоо, төсөв зардлыг бууруулах,

- хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг өргөтгөх зэрэг болно.
- Аймгийн боловсон хүчний цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
 - Үйлдвэрлэл дэд бүтцийг хөгжүүлэх, ХАА-г эрчимжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилчин бэлтгэх тогтолцоог бий болгох;
 - Төрөл бүрийн мэргэжилтэй ажилчин бэлтгэхэд шаардлага бүхий багшлах боловсон хүчнийг сургаж бэлтгэн, нөөцийг бүрдүүлэх;
 - Ховд их сургуулийн зарим танхимын сургалтын агуулгыг өөрчлөх мэргэжилтэй ажилчин бэлтгэх ангиудыг шинээр нээж багшлах боловсон хүчнээр хангах;
 - Төрийн албан хаагчид, түүнчлэн төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагуудын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх мэргэжил, мэргэшлийн хувьд сургаж бэлтгэх бичил хөтөлбөр боловсруулан, боловсон хүчний чадамжийн стандартыг бий болгож мөрдөх;
 - Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллах
 - Төрийн албан хаагчийн мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд нь зориулж тухайн байгууллагаас нь үзүүлдэг санхүүгийн болон эд материалын дэмжлэгийн хүрээг өргөтгөх, нөөц боломжийг судлаж хэрэгжүүлэх;
 - Төрийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхой болгох, дотоод зохион байгуулалт, журмыг боловсронгуй болгох;
 - Төрийн болон төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох;
 - Аймаг, сум, байгууллагын түвшинд төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж мөрдөх;
 - Төрийн албаны стандартыг хэлбэрэлтгүй сахиж мөрддөг болгох;
 - Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагыг аймгийн онцгой байдлын хэлтэс, цагдаагийн газартай холбогдох дохиоллын системтэй болгох;
 - Төрийн байгууллагуудын төсвийг хүрэлцээтэй болгох;
 - Төрийн бус байгууллагын олон нийттэй харилцах давуу талыг түшиглэн нийгмийн сэтгэлгээ, эрэлт хэрэгцээг судалдаг, дүгнэлт шинж:илгээ хийдэг чиг үүрэг бүхий бүтэц орон тоог бий болгох;
 - Сумдыг хууль тогтоомжийн цахим сантай болгох:
 - Хууль тогтоомж сурталчлах, эрх зүйн сургалт явуулахад шаардагдах зардлыг нутгийн захиргааны байгууллагын жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусгаж үр ашигтай зарцуулан сургалтын үр нөлөөг хянаж, мэдээлдэг тогтолцоог бий болгох;
 - Төрийн байгууллагын үйлчилгээнд нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх
 - Төрийн үйлчилгээг иргэдийн хүсэлт шаардлагад нийцүүлэн явуулах зорилгоор нээлттэй хэлэлцүүлэг явуулж хэвшүүлэх:
 - Төрийн байгууллагуудыг вэб хуудастай болгон, нутгийн захиргааны болон төсөвт байгууллагуудыг мэдээллийн нэгдсэн цахим сүлжээнд холбож, төрийн зарим гол үйлчилгээг электрон хэлбэрээр үзүүлж энэ хуудасаар иргэдийн санал хүсэлтийг авдаг болгох;
 - Багийн ажлын албыг компьютержуулах:
 - Аймгийн эдийн засаг нийгмийн гол асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцэхийн өмнө ард иргэдийн дунд хэлэлцүүлэг, санал асуулга явуулж, тэдний санал бодлыг өргөн тусгаж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тэдний оролцоог нэмэгдүүлэх;
 - Аймгийн архивын тасгийг цахим сүлжээнд холбож бүртгэлийн нэгдсэн сантай болгох
 - Бүх шатны иргэдийн хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломж нөхцлийг хангах;

- Шүүх, прокурор, цагдаагийн болон мэргэжлийн хяналтын байгууллага, хамт олны үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй болгох.
- Цагдаагийн газрын хэв журмын тасгийг богино холбоо, эргүүлийн унаагаар хангах
- Хариуцлагын зарчмыг бүх шатанд өндөржүүлэх:
- Иргэн орлого олж татвар төлдөг зах зээлийн хуулийг амьдралд бүрэн хэрэгжүүлэхийг иргэн бүрт хэвшүүлэх.

ТАВ. Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй эдийн засаг, нийгмийн эцсийн үр дүн шаардагдах хөрөнгө, санхүүжүүлэх эх үүсвэр

1. Эдийн засаг, нийгмийн эцсийн үндсэн үр дүн
Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд тус аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн тогтвортой, даац бүхий өндөр хурдацтай болсон байх бөгөөд 2015 он гэхэд зэрэгцүүлсэн үнээр тооцсон ДНБ 2006 оныхоос 2,0 хувиар дахин өсч, боловсруулах үйлдвэрийн жин үлэмжхэн нэмэгдсэн байна. Нэг хүнд ногдох ДНБ 4,0 мянган ам доллар болж 2006 оныхоос 8,5 дахин өснө.

Аймгийн эдийн засгийн бүтцийг салбараар авч үзвэл 12,4 хувийг ХАА, 16,9 хувийг уул уурхай, 16,2 хувийг аж үйлдвэр, барилга, 12,1 хувийг түлш эрчим хүчний, 10,3 хувийг тээвэр, холбооны салбар, 24,7 хувийг худалдаа, 11,4 хувийг үйлчилгээний салбар тус тус үйлдвэрлэн гаргана.

Хүн амын өсөлтийг хангах нөхцөл бүрэлдэж, хүн ам 2015 он гэхэд 2006 оныхоос 6,0 хувийг өссөн байх бөгөөд хүн амын дундаж наслалт 65 – д хүрч, хүний амьдралын үзүүлэлтүүд чанаржин хүний хөгжлийн индекс улсын дундаж түвшинд хүрнэ. Аймгийн 18 хүртэлх насны бүх хүмүүс 8 – 12 жилийн боловсролтой болсон байна.

2. Шаардагдах хөрөнгө, санхүүжүүлэх эх үүсвэр

Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2007 – 2015 онд 263,2 тэр бум ам.долларын хөрөнгө оруулалт хийх тооцоо гарч байна.

Шаардлагат хөрөнгийг санхүүжүүлэхэд дор дурдсан эх үүсвэрийг ашиглах чиглэлийг баримтлана. Үүнд:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр

- Дотоодын банк, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн ашиглах;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих;
- Хуримтлал бий болгох хүн амын сонирхлыг хөхүүлэн дэмжих, бэлэн мөнгийг төвлөрүүлэн ашиглах механизм, эдийн урашууллын тогтолцоог бий болгох,
- Дотоодын хөрөнгө оруулалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ашиглах оновчтой арга механизм, хөшүүргийг бий болгох;
- Үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах хөшүүргийг боловсронгуй болгох;
- Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөө бүхий төслүүдийг санхүүжүүлэх зориулалттай “Бүс нутгийн хөгжлийн сан” байгуулж ажиллахыг идэвхтэй дэмжих,
- Гадаадын улс орон, олон улсын байгууллагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авах;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэн хамтарсан үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулах зэрэг болно.

Урьдчилсан тооцоогоор Улсын сектор 129,7 тэрбум, хувийн хэвшил 133,4 тэрбум ам долларын хөрөнгө оруулалт хийхээр тооцож байна. Үүний зэрэгцээ гадаадын эх

үүсвэр тухайлбал олон улсын болон донор орнуудын зээл, тусламжийг авах арга хэмжээг зохион байгуулах болно.

Б.Шаардлагатай санхүүгийн хэмжээ

Хөтөлбөрийн стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд төрөл бүрийн нөөц санхүүгийн эх үүсвэр шаардагдах бөгөөд санхүүжилтийн хувьд 2007-2015 онд нийт 263,2 сая ам долларын хөрөнгө оруулалт хийх тооцоо гарч байна. Үүнээс улсынх 129,8 сая, хувийн хэвшилд 133,4 сая ам. доллар хөрөнгө орох юм. Гадаад эх үүсвэрт шууд хөрөнгө оруулалтаас гадна олон улсын болон донор орнуудын зээл тусламж, гадаадын шууд хөрөнгө оруулалт орж байна. Шинэ технологи, шинжлэх ухаан багтаамж ихтэй салбар болон дэд бүтцийг хөгжүүлэхэд оруулах хөрөнгийг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагчдын тусламж, эх үүсвэрээс ашиглана. Шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажиллагааг улсын төвлөрсөн төсөв, аймгийн төсвөөс санхүүжүүлнэ. Стратегид тусгагдсан арга хэмжээнүүдийг Монгол улсад байгуулагдах Хөрөнгө оруулалтын банк, Хөрөнгө оруулалтын сан, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, өөрчлөлт шинэчлэлтийн сан зэргээс санхүүжихийн дээр бас бусад боломжит эх үүсвэрийг ашиглана.

В. Стратегийн хэрэгжүүлснээр гарах эдийн засгийн гол дүн

Стратегийг хэрэгжүүлсний үр дүнд Ховд аймаг баруун бүсэд түлш, эрчим хүч, аж үйлдвэр, худалдаа үйлчилгээний томоохон төв болж улмаар өөрийгөө нөхөх эдийн засагтай болно.

Эдийн засгийн бодит өсөлт 18-20 хувьд хүрч 2015 он гэхэд зэрэгцүүлэх үнээр бодсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2006 онтой харьцуулахад 5 дахин өсөж боловсруулах үйлдвэрийн хувийн жин ихээхэн нэмэгдэнэ. Мөн хөдөлмөрийн бүтээмж 4 дахин өсөж хүмүүсийн бодот орлого тэр хэмжээгээр нэмэгдэх юм. 2015 он гэхэд 1 хүнд ноогдох ДНБ 4000 ам долларт хүрч улсын дундаж түвшинд ойртон хүмүүсийн аж амдрал эрс сайжрах болно.

ХАВСРАЛТ 1. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, хүндрэл, бэрхшээл, тасалдлыг арилгаж, хэрэгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрийн бүлэг, дэд бүлэг бүрт багтсан тэргүүлэх зорилтуудын хүрээнд тусгасан үзүүлэлтүүдийг үндэслэн хийнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний үе шатны хяналт-шинжилгээ, үнэлгээг 2011 онд, хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг 2016 онд тус тус гаргана.

Хөтөлбөрийн бүлгийн нэр	Хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үзүүлэлтүүдийн нэр, тэдгээрийг хэмжих нэгж	I үе шатны үзүүлэлт (2006-2010 он)	II үе шатны үзүүлэлт (2011-2015 он)
0	1	2	3
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ	Аймгийн ДНБ-ний жилийн дундаж өсөлт, /%/	18	20
	Аймгийн ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин (үе шатны эцэст), / %/	27,5	35,1
	Аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт, / %/	17	18

	Боловсруулах аж үйлдвэрийн ДНБ-ий жилийн дундаж өсөлт, / %/	12	18
	Аймгийн эрчим хүчний салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт / %/	5,8	12,1
	Аймгийн уул уурхайн салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт, /дахин, %/	20	18
	Аймгийн эрчим хүчний салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт, /дахин/	45	35
	Аймгийн барилгын салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт / %/	24	25
	Аймгийн хөдөө аж ахуйн салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт, / %/	8	9
	Аймгийн газар тариалангийн салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт, / %/	7	8
	Аймгийн мал аж ахуйн салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт / %/	4	5
	Аймгийн худалдааны салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт / %/	12	15
	Аймгийн үйлчилгээний салбарын ДНБ-ий жилийн дундаж өсөлт / %/	15	15
ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ	Аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт, /%/	1,2	1,5
	Хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлт, /индекс/	0,690	0,695
	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах хүүхдийн хувийн жин / %/	70	80
	Сургуулийн насны хүүхдийн хамран сургалт, / %/	90	98
	Эхийн эндэгдлийн бууралт, / %/	Гуравны хоёроор	Гуравны нэгээр
	Нялхсын эндэгдлийн бууралт, / %/	Гуравны хоёроор	Гуравны нэгээр
	Хүн амын дундаж наслалт	64	65
	Ажилгүйдлийн түвшин	3	1
	Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо		

ГУРАВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ	Элсний нүүдлээс хамгаалах зорилгоор байгуулсан ойн зурвасын талбайн өсөлт, (2004 оны түвшингээс) /%/	20	50
	Бэлчээрийн талхагдлын бууралт, (2004 оны түвшингээс) /%/	30	40
	Хөрсний эвдрэлийн бууралт, (2004 оны түвшингээс) /%/	10	15
	Усны бохирдлын бууралт, (2004 оны түвшингээс) /%/	20	25
	Хот суурин газрын агаарын бохирдлын бууралт (2004 оны түвшингээс) /%/	40	70
	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн өсөлт, (2004 оны түвшингээс) /%/	25	50

**ХАВСРАЛТ 2. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ (2006-2010 ОН)**

Хөтөлбөрийн бүлэг, хэрэгжүүлэх арга хэмжээний нэр	Хугацаа	Санхүүгийн эх үүсвэр олох чиглэл	Хөрөнгө оруулалтын тойм тооцоо /тэрбум төг/	Хариуцан гүйцэтгэх байгууллага
0	1	2	3	4
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ				
1.1. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, салбарын зохистой бүтцийг бий болгох бодлого				
.....
.....
.....
ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ				
.....
.....

.....
.....
.....
ГУРАВ. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ				
.....
.....
.....
.....
.....
НИЙТ				

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Монгол Улсын хөгжлийн холбогдолтой зарим тулгуур баримт бичгүүд

1. Монгол улсын Үндсэн хууль. УБ, 1992.
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын 56 дугаар тогтоол. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. УБ, 1994. №9.
3. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ, 1994.
4. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал. УИХ-ын 26-р тогтоол, УБ, 1996.05.03.
5. Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл. УБ, 2004.
6. Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр. УБ, 1999.
7. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2001. №28(215).
8. “Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, Бүс нутгийн удирдлага, төлөвлөлт ном. УБ, 2003. хууд 51-120.
9. “Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай” Монгол Улсын хууль. Бүс нутгийн удирдлага, төлөвлөлт ном. УБ, 2003. хууд 39-49.
10. “Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” УИХ-ын тогтоол. Бүс нутгийн удирдлага, төлөвлөлт ном. УБ, 2003. хууд 38.
11. “Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл”, УИХ-ын 54 дүгээр тогтоол. УБ, 2003.
12. Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал. УБ, 1999.
13. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн дунд хугацааны (1999-2002) хөгжлийн стратеги. УБ, 1999.
14. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. “Өнөөдөр” сонин, 2000.09.09.
15. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2003-2005 оны хөгжлийн хандлага. УБ, 2001.

16. Монгол Улсын Засгийн газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийн бодлого баримт бичиг. УБ, 2001.
17. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (төсөл). УБ, 2002.
18. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг. УБ, 2003.
19. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын илтгэл. УБ, 2003.
20. Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөрийн төсөл. УБ, 2003.
21. Хөдөөгийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого (төсөл), УБ, 2003.
22. Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Монгол Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолын хавсралт.
23. “Зүүн бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, Улаанбаатар, 2004.
24. Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр /2005 он/
25. Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр /2005 он/
26. Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр /2005 он/
27. Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр /2005 он/
28. Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр /2006 он/
29. “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын төсөл. Үндэсний хөгжлийн хүрээлэн.

Хоёр. Төрөлжсөн зарим хөтөлбөр

30. Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөр. УБ, 1996.
31. Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр. УБ, 1998.
32. Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр. УБ, 1998.
33. Эрдэс баялаг хөтөлбөр. УБ, 1998.
34. Хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр. УБ, 1998.
35. Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр. УБ, 2001.
36. Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөр. УБ, 2001.
37. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах үндэсний хөтөлбөр. УБ, 2001.
38. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр. УБ, 2001.
39. Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр. УБ, 2002.
40. Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр. УБ, 2002.
41. Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр. УБ, 2002.
42. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр. УБ, 2002.
43. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр. УБ, 2002.
44. Орон сууц үндэсний хөтөлбөр. УБ, 2002.
45. Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг /2003 он/
46. Монголын боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө /2005 он/
47. Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө /2005 он/
48. Тээврийн салбарын стратеги төлөвлөгөө /2005 он/
49. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр /2005 он/

Гурав. Хөгжлийн бодлоготой холбогдох зарим хэвлэгдсэн материал

50. Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2000. ҮСГ. УБ, 2001.
51. Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2001. ҮСГ. УБ, 2002.
52. Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2002. ҮСГ. УБ, 2003.
53. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдлын тухай танилцуулга. ҮСГ. УБ, 2002.
54. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдлын тухай танилцуулга. ҮСГ. УБ, 2003.
55. Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000. ҮСГ. УБ, 2001.
56. Монгол Улсын хүн амын хэтийн тооцоо. ҮСГ. УБ, 2002.
57. Монгол Улсын хүн ам хорьдугаар зуунд. ҮСГ. УБ, 2003.

58. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2003-2005 оны хөгжлийн хандлага. УБ, 2001.
59. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мэдээлэл (2002 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар). УБ, 2002.
60. Монголын хөгжлийн стратеги (онол, практикийн хандлагууд). Цуврал I-Ү. Монголын хөгжлийн судлалыг дэмжих төв. УБ, 1998-1999.
61. Монгол дахь ядуурлыг бууруулах стратеги. “Тэгш байдал, ядуурлыг бууруулах асуудлыг хөгжлийн стратегид тусгах нь” сэдэвт илтгэл. НҮБХХ, УБ, 2001.
62. Монгол Улсын бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын асуудал. УБ, 2001.
63. Тогтвортой хөгжил: Дэлхийн баримт бичгүүд. УБ, 2002.
64. Монгол орны хөгжлийн чиг хандлага, улс төрийн намуудын байр суурь. Улс төрийн намуудын ярилцлага, №1. УБ, 2002.
65. Монгол Улс ба гадаадын зээл тусламж. Улс төрийн намуудын ярилцлага, №2. УБ, 2002.
66. Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын төлөв байдал, цаашдын хандлага. Улс төрийн намуудын ярилцлага, №3. УБ, 2002.
67. Монгол Улсын XXI зууны хөгжлийн язгуур шинж. УБ, 2002.
68. Эдийн засгийн салбарын хөгжил-2002. УБ, 2002.
69. Монгол Улсын хөгжлийн судалгаа. 2002 (1). Үндэсний хөгжлийн хүрээлэн. УБ, 2002.
70. Монгол Улсын хөгжлийн судалгаа. 2003 (1). Үндэсний хөгжлийн хүрээлэн. УБ, 2003.
71. Монголын хүний хөгжлийн илтгэл 2003. НҮБХХ. УБ, 2003.
72. Монгол орны байгаль орчин. УБ 1996.
73. Дорнод аймгийн статистикийн эмхтгэл, 2000-2003.
74. Хэнтий аймгийн статистикийн эмхтгэл, 2000-2003.
75. Сүхбаатар аймгийн статистикийн эмхтгэл, 2000-2003.
76. Guidelines for integrating women’s concerns into development planning in Asia and The Pacific. Economic and Social Commission for Asia and The Pacific. United Nations, New York, 1991.
77. Training Module on Integrated Population and Development Planning. Philippine, 1993. Manila.
78. The East Asian Miracle. World bank. 1993.
79. Rudger Dornbuseh, Stanley Fischer Macro Economics. 1994.
80. Mark Blang Economic theory in retrospect. Cambridge. 1997.
81. World Bank “RMSM modules guideline’s”. 1998.
82. Development Economics, 2000.
83. “A New Strategy for the Environment” Policy Brief, OECD, Observer, July 2001.
84. World Bank Atlas–2001. World Bank.
85. World Economic and Financial Surveys “World economic outlook-May 2001”. Fiscal Policy and Macroeconomic Stability- International Monetary Fund.
86. World Economic and Financial Surveys “World economic outlook-May 2001”. The information Technology Revolution- International Monetary Fund.
87. UNDP Report Office on Human Development (March 2001), “UNDP Corporate Policy on NHDRs.”
88. UNESCAP (2001), “Reducing Disparities: Balanced Development of Urban and Rural Areas and Regions Within The Countries of Asia and The Pacific.”
89. The World Bank (2001), “Chapter 2: Rural-Urban and Regional Disparities.”
90. World Development Indicators-2001. World Bank. 2002.
91. Fundamental issues affecting sustainability of the Mongolian Khangai. IISNC, Ulaanbaatar, 2002.

Дөрөв. Төр засгийн удирдлага, улс төрчид, эрдэмтэд судлаачдын туурвисан зарим бүтээл (монгол, англи хэл дээр)

92. Багабанди Н. Шинэ зуун. төрийн хэрэг иргэдээсээ, иргэний амьдрал төрөөсөө. УБ, 2002.
93. Багабанди Н. Шинэ зууны өмнөх бодлого, зорилт. УБ, 1998.
94. Багабанди Н. Шинэ зууны өмнөх бодомж, санамж. УБ, 1998.
95. Энхбаяр Н. Монгол улс хөгжих тусам тусгаар тогтнол нь баталгаажна. “Зууны мэдээ” сонин, 2001.07.16.
96. Энхбаяр Н. “Шинэ зуун-шинэ зорилт” МАХН-ын XXIII их хурал дээр тавьсан илтгэл. “Үнэн” сонин. 2001.03.01. №41.
97. Улаан Ч. “Монгол Улсын төсөв, санхүүгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв”. УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаан дээр тавьсан илтгэл. 2002.7-р сар.
98. Улаан Ч. Монгол улс ба гадаадын зээл, тусламж. Үнэн сонин. 2002.02.08.
99. Энхсайхан М., Адъяасүрэн Ц., Дагвадорж Д. “Тогтвортой хөгжил” сурах бичиг. УБ, 2003.
100. Дагвадорж.Д., Цэдэндамба Л. Баруун бүсийн тогтвортой хөгжлийн асуудлууд, шийдвэрлэх зарим арга зам. “Бүс нутгийн хөгжил, мэдээллийн технологи 2002” сэдэвт онол, практикийн бага хурлын материалын эмхтгэл. УБ, 2002.
101. Дагвадорж Д. Тулхтай хөгжил - Монголын ирээдүй. УБ, 2002.
102. Дорж.Т., Нацагдорж В., бусад. Хөгжлийн эдийн засаг. УБ, 2000.
103. Доржнамжаа Д., Будням С., Хаумдас А. Эрдэс-түүхий эдийн нөөц баялаг, чадамж тогтвортой хөгжилд нөлөөлөх үндэс мөн. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2002, №1.
104. Жаргалсайхан.Ж. Макро эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа. “Монгол улс XXI Зууны тогтвортой хөгжлийн төлөө” сэдэвт онол, практикийн бага хуралд тавьсан илтгэл. УБ, 2002.
105. Лувсандорж П., бусад. Монголын эдийн засаг: Шилжилтийн эдийн засгийн гарын авлага. Улаанбаатар, Манчестер. 1999.
106. Нямзагд С. Үндэсний эдийн засгийн стратегийн удирдлага. I-II боть, УБ, 2001.
107. Насанжаргал Д. Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн асуудлууд, цаашдын хандлага. “Монгол улс XXI зууны тогтвортой хөгжлийн төлөө” сэдэвт онол, практикийн бага хуралд тавьсан илтгэл. УБ, 2002.
108. Очирбат П., бусад. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ, 2004.
109. Очирбат П. Үнэт эрдэс баялгийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи. УБ, 2000.
110. Очирбат П. Эрдэс баялгийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи. УБ, 1998.
111. Очирбат П. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал. “Ардын эрх” сонин. 1996.02.14.
112. Ринчинбазар.Р. Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, удирдлагын асуудлууд. УБ, 2004.
113. Хаумдас А. Монгол орны уул уурхай, металлургийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал ба түүний ирээдүй. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2002, №1.
114. Цэдэндамба Л. Тэрбиш.Д. Бүсчилсэн хөгжлийн бодлого ба засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарийн шинэчлэлийн асуудлууд. Монгол Улсын ардчилсан хөгжил ба Үндсэн хууль, УБ, 2005. Хуудас 145-158.
115. Цэдэндамба Л. Бүс нутгуудын хөгжлийн хөтөлбөр боловсруулах аргазүйн нийтлэг хандлага. “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх зарим арга зам (Баруун бүсийн жишээн дээр)” сэдэвт онол, практикийн бага хуралд тавьсан илтгэл. УБ, 2004.

116. Цэдэндамба Л, Жаргалсайхан.Ж, Бадарч.Д, Баярхүү.Ц. Оюу-Толгойн зэс, алт, мөнгөний холимог ордыг ашигласнаар Монгол Улсын болон бүс нутаг, орон нутгийн эдийн засгийн хөгжилд гарах өөрчлөлт, шууд болон шууд бус нөлөөллийн үнэлгээ (Эрдэм шинжилгээний ажлын тайлан). УБ, 2004.
117. Цэдэндамба Л., Ринчинбазар Р. Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах аргазүй, аргачлал. УБ, 2003.
118. Цэдэндамба Л., бусад. Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийн тогтвортой хөгжлийн асуудлууд, шийдвэрлэх зарим арга зам. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2003, №1. УБ, 2003.
119. Цэдэндамба Л., бусад. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал ба бүс нутгийн хөгжил. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2003, №1. УБ, 2003.
120. Цэдэндамба Л., Ринчинбазар Р. Бүс нутгууд дахь ядуурлын асуудлууд. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2003, №1. УБ, 2003.
121. Цэдэндамба Л., Гансэлэм Д. Эдийн засгийн бүсүүдийн мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэлийн чадавхи (потенциаль)-ийн үнэлгээ. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2003, №1. УБ, 2003.
122. Цэдэндамба Л., Гансэлэм Д. Эдийн засгийн бүсүүдийн үйлдвэрлэлийн дэд бүтэц (төрөл бүрийн зам, эрчим хүч, харилцаа холбоо)-ийн хөгжлийн өнөөгийн байдал, үнэлгээ. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2003, №1. УБ, 2003.
123. Цэдэндамба Л., бусад. “Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийн төв (хот, суурин газар)-ийн хөгжлийг төрөөс дэмжих онолын үндэслэл, арга зам” сэдэвт шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд явуулсан судалгаа шинжилгээний ажлын урьдчилсан тайлан. Үндэсний хөгжлийн хүрээлэн. УБ, 2003 он.
124. Цэдэндамба Л., Ринчинбазар Р. Ядуурлыг бууруулах стратегид Монгол улсын бүс нутгуудын ядуурлын асуудлуудыг оновчтой тусгах шаардлага, зарим арга зам. Дэлхийн банкнаас “Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг” боловсруулж байгаа орнуудад зориулан зохион байгуулсан видео хуралд тавьсан илтгэл. УБ, 2002.
125. Цэдэндамба Л., Нямцэрэн Л. Монгол Улсын бүс нутгуудын тогтвортой хөгжлийн асуудлууд, шийдвэрлэх зарим арга зам. “Монгол Улс XXI зууны тогтвортой хөгжлийн төлөө” сэдэвт онол, практикийн бага хуралд тавьсан илтгэл. УБ, 2002.
126. Цэдэндамба Л., Ринчинбазар Р., Гансэлэм Д. Эдийн засгийн бүсүүдийн хөгжлийн тулгуур төвүүдийг илрүүлэн тогтоох арга зүйн асуудалд. “Монгол Улсын хөгжлийн судалгаа” сэтгүүл, 2002, №1.
127. Цэдэндамба Л, Хайсамбуу Д, Намжилмаа С. Монгол улсад бүс нутгийн хот суурин газруудын ангилал, зэрэглэл боловсруулах арга зүйн асуудалд. БАК-ийн эрдэм шинжилгээний бичиг. 2001/1. х 175-187.
128. Цэдэндамба.Л., бусад. Монгол Улсын Өрнөд бүс. УБ, 1999.
129. Цэдэндамба Л. Бүсчилсэн хөгжлийн онол, практикийн асуудлууд. Монгол Улсын Өрнөд бүс ном. УБ 1999. х.8-72.
130. Цэдэндамба Л. Бүсчилэн хөгжүүлж амжилт олсон орнууд бий, тэднээс сурцгаая даа. Өнөөдөр сонин. 1999.05.03. № 101 (65)
131. Чадраа Б., Цэдэндамба Л. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн шинжлэх ухааны үндэслэл, товхимол. УБ, 2001.
132. Чинзориг С. Монгол Улсын Засгийн газраас хүн амын ядуурлыг бууруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилт. “Монгол Улс XXI зууны тогтвортой хөгжлийн төлөө” сэдэвт онол, практикийн бага хуралд тавьсан илтгэл. Улаанбаатар, 2002.
133. Allen G. Noble., Frank J.Costa., and others. Regional Development and Planning for the 21st century. UK, 2000.

134. Benjamin Higgins., Donald J.Savoie. Regional development theories and their application. USA, 1995.
135. Cadman Atta, Mills Ray Nallar Analytical approaches to stabilization and adjustment programs. World bank. 1995.
136. Dennis A.Rondinelli. Applied methods of regional analysis: The spatial dimensions of development policy. USA, 1985.
137. Daniel Felsenstein., Ronald McQuaid., and others. Public investment and regional economic development. UK, 2001.
138. Handbook of Development Economics, volume 1. Elsever, 2002.
139. Harvey Armstrong and Jim Taylor. Regional economics and policy, thirt edition. Oxford University press, 2001.
140. Maurice Schiff., L.Alan Winters. Regional integration and development. Washington, 2003.
141. Rudger Dornbuseh, Stanley Fischer Macro Economics. 1994.
142. Philip McCann. Urban and Regional Economics. Oxford University press, 2001.
143. Somsak Tambunlertchai S.P Gupta., Development Planning in Asia. Asian and Pacific Development Center. 1993.
144. Shelia Page. Regions and development politics, security and economics. London, 2000.
145. Seventh Malaysia plan 1996-2000. Prime ministers department. Kuala Lumpur, 1996.
146. Tsedendamba L., Mongolian Regional Development Indicators and Indexes. Latest economic development issues in the Northeast Asia and Mongolia. UB, 2004.
147. Tsedendamba.L, Pressing issues of Mongolia's regional development, http://www.forum.mn/Features/Feature_articles/Social_and_Economic/Regional_Development/ Pressing issues of Mongolia's regional development/
148. Tsedendamba.L and other, Review of the regional development concept and the medium - term regional development strategy, <http://www.adb.org/MNRM/documents/Review-RDC.pdf>
149. Tsedendamba.L, Indicators and Indexes for Aimags and Regions, www.adb.org/MNRM/documents/Conference-Proceedings.pdf
150. The Second Five-Year Economic Development plan 1967-1971. Government of Republic of Korea. Seoul, 1996.
151. The seventh national economic and social development plan (1992-1996). National economic and social development board office of the prime minister. Bangkok, 1992.